Худалдаа, үйлчилгээний ажилтан	Аялал жуулчлал, гэр ахуйн ажил эрхлэх, нийтийн хоолоор үйлчлэх, хувь хүн асрах, гал түймрээс сэргийлэх, хамгаалах эсвэл бөөний ба жижиглэн худалдаа, бусад төстэй байгууллагад, тэрчлэн зах, мұхлагаар, бараа таваар дэлгэн үзүүлэх, худалдаж борлуулахад холбогдсон хувийн болон хамгаалалтын шинжтэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

Ойлголт	Тодорхойлолт
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэжилтэн	Үр тариа, мод, бут, малын тэжээл ургуулах, зэрлэг жимс, ургамал түүх, ан амьтан үржүүлэх, харж хамгаалах, агнах, төрөл бүрийн амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах, гэр бүлийнхээ хоол хүнсэнд зориулан загас үржүүлэх буюу барих, усны бусад төрөл зүйлийг өсгөж үржүүлнэ.
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Барилга барих, арчлах, металлд хэлбэр оруулах, металл бүтээцийг босгох, автомат бүтээцийг босгох, автомат багаж хэрэгслийг тохируулах, машин механизм, тоног төхөөрөмж, багаж хийх, тааруулах, засварлах, хэвлэх ажлын бүтээгдэхүүн гаргах, хүнсний зүйл, нэхмэл эдлэл, модон, металл, бусад эд бараа, түүний дотор гар урлалын зүйл үйлдвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
Машин механизм, төхөөрөмжийн оператор, угсрагч	Уул уурхайн аж үйлдвэрийн бусад салбар тухайлбал металл боловсруулах, эрдэс, шил, керамик, мод, цаас болон химийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, үс цэвэрлэх, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, тоног төхөөрөмжийг монтажлах, ажиллуулах, хянах зэрэг ажил, үүрэг гүйцэтгэнэ.
Энгийн ажил, мэргэжил	Олон нийтийн газар, гудамж талбайд буюу айл дамжиж бараа худалдаалах, гудамжинд төрөл бүрийн үйлчилгээ хийх, цэвэрлэгээ, угаалга хийх, индүүдэх, айлын орон гэр, зочид буудал, албан тасалгаа, болон бусад байрыг арчилж тордох, цонх, барилга, байшингийн бусад үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	Зэвсэгт хүчний ажил, мэргэжилд зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний гүйцэтгэдэг бүх ажил орно. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн нь цэргийн алба хаагч болон цэргийн анги байгууллагад гэрээгээр ажиллагчдаас бүрдэнэ. Энэ бие бүрэлдэхүүнд зэвсэгт хүчний жанжин штаб, ерөнхий зориулалтын болон агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлал, төрөл, мэргэжлийн цэргийн ба ар тал техникийн нэгтгэл, ангиуд, цэргийн сургууль, сургалт эрдэм шинжилгээ, соёл урлаг, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, аж ахуй, үйлчилгээний байгууллагуудад цэргийн алба хааж буй болон хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа хүмүүс багтана.
СУУЦНЫ ТӨРӨЛ, ЦАХИЛГААН, УНДНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН АНГИЛАЛ	
Гэр	Бүх төрлийн монгол гэр, цаатны үрц хамаарна.
Байшин	Байшинд нэг болон олон өрөөтэй, дээвэртэй, гадуураа ханатай, сууринаас дээвэр хүртэл хананаас хуваагдсан талбай бүхий орон байр багтана.
Майхан	Бүх төрлийн майхныг энд багтана.
Түр оромж	Анхнаасаа хүн амьдрахад зориулж бариагүй эсвэл хүн амьдрахад засаж тохижуулан өөрчилсөн, хүн амьдарч байгаа түр оромжийг хамруулна.
Нүхэн сууц	Анхнаасаа хүн амьдрахад зориулж бариагүй эсвэл хүн амьдрахад засаж тохижуулан өөрчилсөн, хүн амьдарч байгаа нүхэн сууцыг хамруулна.
Бусад сууц	Дээрх сууцны төрлөөс бусад сууцны төрлийг хамруулна.



БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН - 2016

Ойлголт	Тодорхойлолт
Төвлөрсөн систем	Улсын цахилгаан болон усан станцаас цахилгаан хэрэглэж байвал тухайн сууцыг төвлөрсөн системтэй гэж үзнэ. Төвлөрсөн цахилгаан станцад холбогдсон дэд станцыг төвлөрсөн гэж үзнэ.
Дизель станц	Тухайн орон нутгийн хувьд бие даасан дизель станцтай холбогдсон болон цахилгааны сүлжээтэй холбогдсон орон сууцыг хамруулна.
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Нар, салхины эрчим хүчийг хуримтлуулан цахилгаан эрчим хүч бий болгодог төхөөрөмжийг хамруулна.
Бага оврын цахилгаан үүсгүүр	Тухайн өрх нэг болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах зорилгоор шатах болон бусад материалаар ажилладаг бага оврын мотор, цахилгаан үүсгүүрийг хамруулна.
Төвлөрсөн ус түгээх систем	Улсын болон тухайн орон нутгийн усан хангамжийн төвлөрсөн системээс бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин, орон сууцны байшин, нийтийн эзэмшлийн бусад байранд төвлөрсөн байдлаар ус түгээж байгаа усны системийг хэлнэ.
Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр	Хот суурин газрын гэр хорооллын төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон ус түгээх байр орно.
Хамгаалагдсан худаг	Зураг төслийн дагуу баригдсан мотор буюу бусад төхөөрөмжөөр усаа шууд авдаг, дээгүүрээ байгууламжтай, эрүүл ахуйн бүс тогтоож хашсан, хамгаалалтад байдаг, мал амьтан орох боломжгүй худгийг хамруулна. Үүнд өрөмдмөл гүний худаг орно.
Хамгаалагдсан булаг, шанд	Тусгай хамгаалалтад байдаг, засаж тохижуулсан, хашиж хамгаалсан, мал, амьтан орох боломжгүй булаг, шандыг хамгаалагдсан гэж үзнэ.
Цэвэршүүлэн савласан ус	Аж ахуйн нэгжүүд зөвшөөрөл авч, стандартад нийцүүлэн, цэвэршүүлэн савласан үндны зориулалтаар бэлтгэгдсэн усыг хэлнэ.
Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр	Эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжийн зориулалтын авто машинаар ус түгээх байрт зөөвөрлөн түгээдэг байр багтана.
Зөөврийн ус	Эрх бүхий байгууллага, хувийн аж ахуйн нэгж, иргэд хувиараа машин болон ердийн хөсгөөр айл өрхөд шууд зөөвөрлөн түгээдэг бол энд орно.
Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд	Иргэд өөрсдөө ухаж гаргасан, хамгаалалтгүй уурхайн худаг, булаг, шанд орно. Мөн гол, мөрөн, нуур, бороо, цасны болон тогтоол усыг хамруулна.

1.5 СУДАЛГААНЫ АСУУЛГА, ТҮҮНИЙ АГУУЛГА

Энэ удаагийн судалгааны асуулгыг өмнөх судалгааны асуулгыг сайжруулж, бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны онцлог, хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага зэргийг харгалзаж боловсруулсан бөгөөд тэдний өнөөгийн дүр төрхийг харуулж чадахуйц 10 бүлэг, 106 үндсэн үзүүлэлт бүхий маягыг орон нутагт судалгааг зохион байгуулах судлаач нарт зориулсан маягт нөхөх зааврын хамт боловсруулсан.

Судалгааны асуулгын эхний хувилбарыг боловсруулсны дараа нийслэлийн Налайх дүүрэгт гар аргаар нүүрс олборлодог иргэд, Сэлэнгэ аймгийн Түнхэл сумын үндсэн ордод алт олборлодог иргэд, Төв аймгийн Заамар сумын шороон ордод алт олборлодог иргэдээс асуулга авч, туршин санал, зөвлөмжийг тусгасан.

Түүнчлэн 18 аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар болон Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөл, Эрчим хүчний яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам зэрэг холбогдох байгууллагын саналыг авч, санал, зөвлөмжийг тусгасан.

Судалгааны асуулгыг эцэслэн ҮСХ-ны Аргазүйн байнгын зөвлөл болон Даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн ҮСХ-ны даргын 2016 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/20 тоот тушаалаар батлуулсан.

Судалгааны асуулга нь дараах бүтэцтэй. Үүнд:

- Бүлэг 1. Хаягийн хэсэг:** Бичил уурхай эрхлэгчдийн байршлын мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, ашигт малтмалын орд газрын түвшинд цуглуулахуйц 8 асуулт;
- Бүлэг 2. Ерөнхий мэдээлэл:** Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн, нас, хүйс, боловсрол, мэргэжил, ам бүл зэрэг ерөнхий мэдээллийг агуулсан 9 асуулт;
- Бүлэг 3. Ажил эрхлэлт:** Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа, сууцны нөхцөл, цахилгаан, усны эх үүсвэр зэрэг ажил эрхлэлтийн мэдээллийг агуулсан 17 асуулт;
- Бүлэг 4. Хүүхдийн эрх:** Бичил уурхайд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, оролцож буй хэлбэр, бэртэл гэмтлийн талаарх 10 асуулт;
- Бүлэг 5. Мэдээллийн хэрэгцээ, мэдээлэл авах суваг:** Бичил уурхай эрхлэгчдийн мэдээлэл хүлээн авдаг эх үүсвэр, интернет, гар утасны хэрэглээ зэрэг үзүүлэлтүүдийн талаарх 4 асуулт;
- Бүлэг 6. Бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдээлэл:** Бичил уурхай эрхлэгчдийн бэртэл, гэмтэл, өвчлөлт, эмнэлгийн тусламж авах боломжийн талаарх 8 асуулт;
- Бүлэг 7. Нийгэм, орон нутагт оруулсан хувь нэмэр:** Бичил уурхай эрхлэгчдийн хамрагдсан даатгал, түүний төрөл, өөрсдийн амьжиргаанд орсон өөрчлөлт болон орон нутагт оруулсан хувь нэмэр зэрэг 8 асуулт;
- Бүлэг 8. Тусламж, дэмжлэг, тулгарч буй хүндрэл, бэрхшээл:** Бичил уурхай эрхлэх явцад тулгарч буй хүндрэл, бэрхшээл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх 16 асуулт;
- Бүлэг 9. Тоног, төхөөрөмж:** Бичил уурхайн үйл ажиллагаандаа ашигладаг тоног, төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэхийг багтаасан 5 асуулт;
- Бүлэг 10. Үйл ажиллагааны талаарх мэдээлэл:** Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаанаас олсон орлого, зарцуулсан зардал, төлсөн татвар, хураамж зэрэг эдийн засгийн холбогдолтой үзүүлэлтийг багтаасан 21 асуултаас тус тус бүрдэж байна (Маягыг Хавсралт 1-ээс харна уу).

1.6 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

1.6.1 Мэдээллийг оруулах бүрдүүлэлтийн үе шат

Судалгааны мэдээллийг компьютерт оруулах, шалгах, засварлах програм хангамжийн бодлогын даалгаврыг ҮСХ-ны ЭЗСГ-ын ажилтнууд, програм хангамжийг МТГ-ын ажилтнууд боловсруулсан.

Цуглуулсан судалгааны асуулгыг ҮСХ-нд ирүүлэх ажлыг аймаг, нийслэлийн судалгааны ажлын хэсэг хариуцан ажилласан. Судалгааны мэдээллийг компьютерт шивэх ажлыг гэрээт ажилтан, мэдээллийг шалгах, засварлах ажлыг ҮСХ-ны ажлын баг гүйцэтгэлээ.

Мэдээллийг компьютерт оруулах програм хангамжийг CSPRO програм хангамжийг, анализ, дүн шинжилгээг статистикийн шинжилгээний SPSS програм хангамжийг ашиглаж боловсрууллаа. Судалгаа явуулсан БУЭС-I маягтын мэдээлэл хадгалах хэсэг болон програмд ашиглагдах бүх төрлийн код, утгыг агуулсан файл үүсгэж, Microsoft Access програм дээр мэдээллийн санг байгуулсан.

1.6.2 Мэдээллийн алдааг хянах, шалгах үе шат

Судалгааны асуулгад тусгагдсан үзүүлэлт хоорондын уялдаа, тэдгээрийг бүрэн нөхсөн эсэх, шалгалтуудыг хийж, холбогдох засварыг хийсэн. Тухайлбал, хаягийн хэсгийн бүрдэлт, нас, хүйс, регистрийн дугаарын уялдаа, боловсрол, ажил, мэргэжлийн уялдаа, ажил эрхлэлт, орлого, зардал зэрэг үзүүлэлтийг үнэн зөв нөхөгдсөн эсэхийг статистик анализ дээр тулгуурласан хамаарлын болон логик шалгалтуудыг хийж, холбогдох засварыг хийсэн.

1.6.3 Мэдээллийн чанарын үе шат


ҮСХ-ны зүгээс мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын үе шат бүрд мэдээллийн чанарт ихээхэн анхаарч ажилласан бөгөөд аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд орд газруудад баг болж ажилласан. Мөн ҮСХ-ны багийн гишүүд Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймагт судалгааны хамралтыг сайжруулах, орон нутагт дэмжлэг үзүүлэх, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.

1.6.4 Үр дүнгийн хүснэгт бэлтгэсэн тухай

Судалгааны үр дүнгийн 120 гаруй хүснэгтийг боловсруулж гаргасан бөгөөд үр дүнгийн хүснэгтийг эцэслэхийн өмнө үр дүнг Ашигт Малтмал Газрын тосны газрын бичил уурхай эрхлэгчдийн холбогдох мэдээлэл, Монгол Улсын эрдэнэсийн санд худалдсан алтны мэдээ, Стандартчилал хэмжил зүйн газрын Улсын сорьцын хяналтын хэлтсийн лабораториор сорьц тогтоолгосон алтны мэдээ, Татварын ерөнхий газрын бичил уурхай эрхлэгч иргэдийн төлсөн татварын мэдээ, ҮСХ-ны нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүн, Улаанбаатар хотын иргэдийн нүүрсний хэрэглээ, ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн албан ёсны статистик мэдээллийн эх үүсвэрүүдтэй үр дүнг тулгаж шалгасан.

Судалгааны үр дүнгийн хүснэгтэд үндэслэн нэгдсэн тайланг бэлтгэж, ажлын хэсгийн хуралд танилцуулж, хэлэлцүүлснээр холбогдох шийдвэрийг гаргуулав. Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажлыг ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газар гүйцэтгэсэн ба мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажлыг дараах үе шатаар явуулсан.

Зураг 1. Судалгааны мэдээлэл цуглуулах болон боловсруулах ажлын схем



2

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгаанд
нийт 9.6 мянган бичил уурхайн үйл ажиллагаанд
оролцогч иргэд хамрагдлаа.

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүйн зэрэгцээ газарзүйн янз бүрийн бүсэд оршдог, байгалийн баялаг нь орон нутагт жигд бус тархсан, уур амьсгалын хувьд эрс тэс ялгаатай байдлаас хамааран аймаг, нийслэлийн хүн ам, тэр дундаа бичил уурхай эрхлэгчдийн төвлөрөл, үйл ажиллагааны хөгжлийн түвшин харилцан адилгүй байна.

2.1. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧИД

Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгааны дүнгээр нийт 11962 иргэд бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаагаас 9596 иргэн судалгаанд хамрагдаж, 2366 иргэн нь судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн ам бүлийн гишүүн буюу бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байна.



Нийт бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид болон бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй гэр бүлийн гишүүдийн 4.5 мянга буюу 37.6 хувь нь Баруун бүсэд, 4.2 мянга буюу 35.2 хувь нь Төвийн бүсэд, 1.7 мянга буюу 14.9 хувь нь Хангайн бүсэд, 1.3 мянга буюу 10.6 хувь нь Улаанбаатар хотод, 0.2 мянга буюу 1.7 хувь нь Зүүн бүсэд бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 1. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид, бүсээр

Бүс	БҮГД	Судалгаанд хамрагдсан	Ам бүлийн гишүүдээс
БҮГД	11 962	9 596	2366
Баруун	4 503	3 597	906
Хангайн	1 780	1 300	480
Төвийн	4 209	3 312	897
Зүүн	203	171	32
Улаанбаатар	1 267	1 216	51

Бичил уурхай эрхлэгчдийн судалгаанд нийт 9.6 мянган иргэн бие даан бичил уурхайн үйл ажиллагаанд оролцдог гэж хамрагдсан бөгөөд, үүний 3.6 мянга буюу 37.5 хувь нь Баруун бүсэд, 1.3 мянга буюу 13.5 хувь нь Хангайн бүсэд, 3.3 мянга буюу 34.5 хувь нь Төвийн бүсэд, 0.2 мянга буюу 1.8 хувь нь Зүүн бүсэд, 1.2 мянга буюу 12.7 хувь нь Улаанбаатар хотод байршилтай байна.


Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 2.3 мянга буюу 24.0 хувь нь эмэгтэй иргэд байгаа нь өмнөх судалгааны дүнгээс 1.6 мянга буюу 41.2 хувиар буурсан байна.

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид Сүхбаатар, Дархан-Уул, Орхон аймгаас бусад 18 аймаг, нийслэлийн 1 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаагийн 1674 буюу 17.4 хувь нь Говь-Алтай аймагт, 1216 буюу 12.7 хувь нь Улаанбаатар хотод, 998 буюу 10.4 хувь нь Өмнөговь аймагт, 898 буюу 9.4 хувь нь Сэлэнгэ аймагт, 821 буюу 8.6 хувь нь Ховд аймагт, 745 буюу 7.8 хувь нь Баянхонгор аймагт, 657 буюу 6.8 хувь нь Төв аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа нь нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 73.0 хувийг эзэлж, үлдсэн 27.0 хувь нь бусад аймагт байна.

Хүснэгт 2. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид, бүс, хүйсээр

Бүс	2012	Эмэгтэй		2016	Эмэгтэй
		2012	2016		2016
БҮГД	13 375	3 915	9 596	2 301	
Баруун	3 380	1 010	3 597	857	
Хангайн	3 967	1 355	1 300	380	
Төвийн	4 403	1 295	3 312	879	
Зүүн	365	87	171	39	
Улаанбаатар	1 260	168	1 216	146	

Зураг 2. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид, аймаг, нийслэл, бичил уурхай эрхлэгчдийн тооны бүлгээр



Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоог нутаг дэвсгэрийн байршлаар нь авч үзвэл, 18 аймгийн 97 сүм, нийслэлийн 1 дүүргийн ашигт малтмалын илрэл бүхий 113 орд газрын 332 цэг, уурхайн аманд үйл ажиллагаа явуулж байгаа иргэд хамрагдлаа.

2.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧИД, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖЭЭР

Хүснэгт 3. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид, аймаг, нийслэл, засаг захиргааны харьяаллаар

Засаг, захиргааны харьяалал (Үндсэн захиргаа)

Үйл ажиллагаа явуулж байгаа аймаг, нийслэл	АР	БӨ	БХ	БУ	ГО	ДО	ДД	ДУ	ЗА	ӨВ	ӨМ	СҮ	СЗ	ТӨ	УВ	ХО	ХӨ	ХЭ	ДА	ОР	ГС	УБ
АР	126		2							1												
БӨ		137																				
БХ			736			2					2			1								4
БУ				39						1												3
ГО		1	24		18				4	1				1	1	5			2	3		29
ДО						83	1	1		1						1	1				1	3
ДД							50															
ДУ								576			1							1				4
ЗА									396							1						4
ӨВ	1									281												2
ӨМ			2			1		2		2	985							2				4
СЗ									2		1		51	2			2		4	1		6
ТӨ	16		1				2		9		1			370			5	1	2	11		22
УВ	3								2						530	1			1	1		1
ХО																540						
ХӨ																	99					
ХЭ						5												104	1		1	10
ГС																				60		
УБ	12		4			2	4	2	3	8		3		25	4	9	17	6	12	6		1077



Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдыг засаг захиргааны харьяаллаар авч үзвэл Баян-Өлгий, Дорнод, Ховд, Хөвсгөл, Говьсүмбэр аймгуудад бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй иргэд тухайн нутгийн харьяат иргэд байж, Сэлэнгэ аймагт бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн 73.9 хувь нь тухайн нутгийн харьяат, 8.7 хувь нь Улаанбаатар хотын харьяат, үлдсэн 17.4 хувь нь бусад аймгийн харьяат иргэд бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаа бол Говь-Алтай аймагт бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн 20.2 хувь нь тухайн нутгийн харьяат, 32.6 хувь нь Улаанбаатар хотын харьяат, үлдсэн 47.2 хувь нь бусад аймгийн харьяат иргэд байна. Харин Сүхбаатар, Дархан-Уул, Орхон аймгуудаас бусад аймгийн харьяат бичил үйл ажиллагаанд оролцогчдын 74.0-99.0 хувь нь тухайн бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа нутгийнхаа харьяат байна.

2.3 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл, 2.0 хувь нь 10-19 насных, 22.5 хувь нь 20-29 насных, 32.1 хувь нь 30-39 насных, 27.7 хувь нь 40-49 насных, үлдсэн 15.7 хувь нь 50 ба түүнээс дээш насны иргэд байна. Эндээс харахад нийт бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын дийлэнх нь эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу 20-54 насных байгаа нь орон нутагт байнгын ажлын байр хомс байгааг харуулж байна. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын хүйс, насны бүлгээрх дэлгэрэнгүй үзүүлэлтийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг	2012		2016	
	Эмэгтэй		Эмэгтэй	
БҮГД	13 375	3 915	9 596	2 301
10-14	236	111	6	1
15-17	329	102	30	5
18-19	363	108	152	23
20-24	1 765	419	759	116
25-29	2 011	475	1 396	244
30-34	2 090	560	1 519	270
35-39	2 013	602	1 565	432
40-44	1 787	616	1 461	412
45-49	1 439	491	1 199	347
50-54	844	291	896	265
55-59	355	100	429	139
60-64	94	22	134	31
65-69	37	14	41	14
70 +	12	4	9	2

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдыг хүйсээр харвал, 76.0 хувь нь эрэгтэй, 24.0 хувь эмэгтэй, хүйсийн харьцаа 100 эрэгтэй тутамд 32 эмэгтэй ногдож байна. Харин уг үзүүлэлтийг насны бүлгээр авч үзвэл, 18-24 насныхны хувьд хамгийн бага буюу 100 эрэгтэй тутамд 18 эмэгтэй ногдож байгаа бол 50-59 насныхны хувьд 100 эрэгтэй тутамд 44 эмэгтэй ногдож байна.


Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогч эмэгтэй иргэдийг насны бүлгээр авч үзвэл, 1.3 хувь нь 10-19 насных, 15.6 хувь нь 20-29 насных, 30.5 хувь нь 30-39 насных, 33.0 хувь нь 40-49 насных, үлдсэн 19.6 хувь нь 50 ба түүнээс дээш насны иргэд байна.

Хүснэгт 5. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид, бүс, насны бүлгээр

Бүс	БҮГД	10-14	15-17	18-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
БҮГД	9 596	6	30	152	759	1 396	1 519	1 565	1 461	1 199	896	429	134	41	9
Баруун	3 597	2	14	59	269	469	532	548	610	506	354	162	60	10	2
Хангайн	1 300	2	5	31	92	203	207	226	180	142	127	60	21	4	-
Төвийн	3 312	2	7	39	260	485	511	563	504	395	307	171	43	20	5
Зүүн	171	-	-	2	11	21	25	27	30	28	14	6	4	2	1
Улаанбаатар	1 216	-	4	21	127	218	244	201	137	128	94	30	6	5	1

Улсын хэмжээнд 70 ба түүнээс дээш насны 9 иргэн бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж, тэдний 5 нь Төвийн бүсэд, үлдэх 4 нь Баруун, Зүүн бүс болон Улаанбаатарт байна.

Зураг 3. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын нас, хүйсийн суварга



Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоог ижил интервалтай насны бүлгээр авч үзвэл, эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтээс илүү байгаа нь эрэгтэйчүүд бичил уурхайн үйл ажиллагаанд илүү давамгайл байдлаар оролцогийг харуулж байна.

2.4 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшин, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд нь боловсролын түвшингээс ихээхэн хамаардаг. Өөрөөр хэлбэл, хүн амын амьжиргааны түвшнийг нэмэгдүүлэх нэг чухал үзүүлэлт нь боловсролын асуудал гэж үзэж болно.

Хүснэгт 6. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын боловсролын түвшин, бүсээр

Бүс	БҮГД	Боловсролгүй	Боловсролтой	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
БҮГД	9 596	215	9 381	1 020	3 523	3 441	485	289	623
Баруун	3 597	81	3 516	446	1 309	1 245	143	120	253
Хангайн	1 300	39	1 261	246	526	373	52	18	46
Төвийн	3 312	63	3 249	253	1 320	1 150	164	113	249
Зүүн	171	1	170	14	37	90	12	6	11
Улаанбаатар	1216	31	1 185	61	331	583	114	32	64

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 0.2 мянга буюу 2.2 хувь нь боловсролгүй, 9.4 мянга буюу 97.8 хувь нь боловсрол эзэмшсэн иргэд байна. Үүнд, 1.0 мянга буюу 10.9 хувь нь бага боловсролтой, 3.5 мянга буюу 37.6 хувь нь суурь боловсролтой, 3.4 мянга буюу 36.7 хувь нь бүрэн дунд боловсролтой, 0.5 мянга буюу 5.2 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролтой, 0.3 мянга буюу 3.1 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 0.6 мянга буюу 6.6 хувь нь дээд боловсролтой байна.

Хүснэгт 7. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын боловсролын түвшин, хувиар, хүйсээр

Боловсролын түвшин	БҮГД		Эрэгтэй		Эмэгтэй	
	2012	2016	2012	2016	2012	2016
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	4.1	2.2	4.2	2.4	4.0	1.6
Боловсролтой	95.9	97.8	95.8	97.6	96.0	98.4
Бага	14.0	10.6	14.9	11.0	11.7	9.4
Суурь	27.9	36.7	28.6	37.6	26.4	33.9
Бүрэн дунд	40.4	35.9	39.3	35.4	42.8	37.4
Техникийн болон мэргэжлийн	6.8	5.1	7.3	5.2	5.3	4.7
Тусгай мэргэжлийн дунд	2.6	3.0	2.0	2.5	4.3	4.7
Дээд	4.2	6.5	3.7	5.9	5.5	8.3

Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад боловсролтой бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын эзлэх хувь 1.9 пунктээр өсөж, үүнээс суурь боловсролтой иргэдийнх 8.8 пунктээр, тусгай мэргэжилтэй иргэдийнх 0.4 пунктээр, дээд боловсролтой иргэдийнх 2.3 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

2.5 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ МЭРГЭЖИЛ

Судалгаанд хамрагдсан 9.6 мянган бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 5.4 мянга буюу 56.0 хувь нь мэргэжилгүй, 1.4 мянга буюу 14.1 хувь нь машин механизм, төхөөрөмжийн оператор, угсрагч, 0.9 мянга буюу 8.9 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан, 0.8 мянга буюу 8.0 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 0.7 мянга буюу 7.2 хувь нь мэргэжилтэн, үлдэх 5.7 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, техникч болон туслах/дэд мэргэжилтэн, контор, үйлчилгээний, энгийн ажил болон бусад мэргэжилтэй иргэд байна.

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын ажил, мэргэжлийн онцлогоос хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүд ажил, мэргэжлийн ангилал бүрд ялгаатай байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 8. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид, ажил мэргэжил, хүйсээр

Ажил мэргэжлийн бүлэг	БҮГД		Эрэгтэй		Эмэгтэй	
	2012	2016	2012	2016	2012	2016
БҮГД	13 375	9 596	9 460	7 295	3 915	2 301
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	3	7	3	7	-	-
Менежер	10	35	7	24	3	11
Мэргэжилтэн	832	694	487	395	345	299
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	86	166	55	129	31	37
Контор, үйлчилгээний ажилтан	45	36	17	16	28	20
Худалдаа, үйлчилгээний ажилтан	395	229	46	28	349	201
ХАА, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	883	853	579	622	304	231
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, үйлчилгээ	907	767	654	646	253	121
Машин механизм, төхөөрөмжийн оператор	1 961	1 357	1 877	1 305	84	52
Энгийн ажил, мэргэжил	56	76	51	53	5	23
Мэргэжилгүй	8 197	5 376	5 684	4 070	2 513	1 306

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын эзэмшсэн мэргэжлийг бүсээр авч үзвэл, мэргэжилгүй иргэдийн 38.1 хувь нь Баруун бүсэд, 32.7 хувь нь Төвийн бүсэд, 15.8 хувь нь Хангайн бүсэд, 10.9 хувь нь Улаанбаатарт, 2.4 хувь нь Зүүн бүсэд, харин машин механизм, төхөөрөмжийн оператор, угсрагчийн мэргэжилтэй бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 44.1 хувь нь Төвийн бүсэд, 26.2 хувь нь Баруун бүсэд, 22.3 хувь нь Улаанбаатарт, 6.6 хувь нь Хангайн бүсэд, 0.8 хувь нь Зүүн бүсэд байна.

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад машин механизм, төхөөрөмжийн оператор, угсрагч мэргэжилтэй иргэдийн эзлэх хувь 0.5 пунктээр, худалдаа, үйлчилгээний ажилтны 0.6 пунктээр, мэргэжилгүй иргэдийнх 5.3 пунктээр буурч, бусад мэргэжилтэй иргэдийн эзлэх хувь 0.1-2.3 пунктээр өссөн байна.

Хүснэгт 9. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид, бүс, ажил мэргэжлээр

Бүс	БҮГД	Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	Менежер	Мэргэжилтэн	Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	Контор, үйлчилгээний ажилтан	Худалдаа, үйлчилгээний ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний	Машин механизм, төхөөрөмжийн оператор, угсрагч	Энгийн ажил, мэргэжил	Мэргэжилгүй
БҮГД	9 596	7	35	694	166	36	229	853	767	1 357	76	5 376
Баруун	3 597	4	10	271	50	10	70	533	216	356	27	2 050
Хангайн	1 300	-	6	68	8	3	25	171	73	89	8	849
Төвийн	3 312	3	13	285	74	22	101	134	293	599	29	1 759
Зүүн	171	-	2	11	4	-	1	-	11	11	1	130
Улаанбаатар	1 216	-	4	59	30	1	32	15	174	302	11	588

2.6 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АМ БҮЛИЙН ТОО


Энэ хэсэгт бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын ам бүлийн тоог авч үзлээ.

Хүснэгт 10. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид, хувиар, ам бүлийн тооны бүлгээр

Бүс	БҮГД	1	2-5	6-9	10+
БҮГД	100.0	6.0	77.0	16.6	0.4
Баруун	100.0	3.2	76.5	20.1	0.2
Хангайн	100.0	7.0	75.0	16.8	1.2
Төвийн	100.0	7.5	78.2	14.1	0.2
Зүүн	100.0	11.7	75.4	11.7	1.2
Улаанбаатар	100.0	8.1	77.8	13.7	0.4

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын ам бүлийн тоог бүсээр авч үзвэл, 75.0-77.8 хувь нь 2-5 ам бүлтэй байна. Ам бүлийн дундаж тоо Баруун бүсэд хамгийн өндөр байгаа бөгөөд улсын дунджаас нэг хүнээр илүү байна.

Зураг 4. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын ам бүлийн тоонд эзлэх хувь




Судалгаанд хамрагдсан 9.6 мянган бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 77.0 хувь нь 2-5 ам бүлтэй, 16.6 хувь нь 6-9 ам бүлтэй, 6.0 хувь нь 1 ам бүлтэй, 0.4 хувь нь 10 ба түүнээс дээш ам бүлтэй, дунджаар 4 ам бүлтэй байна.

2.7 БИЧИЛ УУРХАЙН ОРД ГАЗРЫН ТОО


Ашигт малтмалын илрэл бүхий нийт 113 (бичил уурхайн зориулалтаар дүгнэлт гаргасан) орд газрын 332 цэг, аманд бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаагийн 205 буюу 61.7 хувь нь 4 аймаг, 1 дүүрэгт байршиж, тэдгээрийн 88 нь Налайх дүүрэгт, 37 нь Баянхонгор аймагт, 29 нь Төв аймагт, 29 нь Өмнөговь аймагт, 22 нь Говь-Алтай аймагт байршиж байна.

Зураг 5. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоо, орд газрын тоо, аймаг, нийслэлээр




Ашигт малтмалын орд олонтой дээрх 4 аймаг, нэг дүүрэгт 5.5 мянган бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид байгаа бөгөөд үүний 1.7 мянга буюу 17.4 хувь нь Говь-Алтай аймагт, 1.2 мянга буюу 12.7 хувь нь Налайх дүүрэгт, 1.0 мянга буюу 10.4 хувь нь Өмнөговь аймагт, 0.7 мянга буюу 7.8 хувь нь Баянхонгор аймагт, 0.6 мянга буюу 6.8 хувь нь Төв аймагт байна.

Зураг 6. Нэгж орд газарт ногдох бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоо, аймаг, нийслэлээр



Нэгж орд газарт ногдох бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоо улсын дунджаар 29 байгаа бөгөөд үүнийг аймаг, нийслэлээр авч үзвэл Дундговь аймагт 83, Говь-Алтай аймагт 76, Завхан аймагт 71, Сэлэнгэ аймагт 56, Ховд аймагт 46, Увс аймагт 45, Өмнөговь аймагт 34, Архангай аймагт 32, Говьсүмбэр аймагт 30 ногдож, бусад аймаг нэгж орд газарт ногдох бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоогоор улсын дунджаас нягтаршил багатай байна.

Зураг 7. Бичил уурхайд ашиглагдаж буй орд газрын байршил, ашигт малтмалын төрөл, аймаг, нийслэлээр



Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоогоор уул уурхайн салбарын голлох нэр төрөл болох алт, нүүрсний илрэл бүхий орд газар ихтэй Баянхонгор, Төв, Увс, Улаанбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл зэрэг аймгууд тэргүүлж байна. Харин жонш, гянтболд зэрэг ашигт малтмалын илрэл бүхий орд газартай Зүүн бүсийн аймгууд доогуур байранд орж байна. Үүнээс харахад бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын төвлөрөл нь ашигт малтмалын төрлөөс шууд хамааралтай байна.

3

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгаанд нийт 6.0 мянган бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгч иргэд хамрагдлаа.

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Энэ бүлэгт бичил уурхай эрхлэгчдийг ажил эрхлэлтийн байдал, ажил, мэргэжлийн ангилал, ажилласан жил, бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй үүрэг хариуцлага, уг үйл ажиллагааг эрхлэх болсон шалтгаан зэрэг үзүүлэлтээр авч судалсан.

3.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгаанд нийтдээ 9.6 мянган иргэн хамрагдсан нь 2012 оны судалгаанд хамрагдсан иргэдээс 3.8 мянга буюу 28.3 хувиар доогуур байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 1.3 хувь нь хоршооны ахлагч, гишүүн, 10.1 хувь нь гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч, 19.7 хувь нь бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч, 21.1 хувь нь нөхөрлөлийн ахлагч, гишүүн, 47.8 хувь нь хувиараа/дангаараа ашигт малтмал олборлогч иргэд байна.

Зураг 8. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын тоо, ажил эрхлэлтийн төрлөөр



Нөхөрлөлийн ахлагч, гишүүд 2024 байгаагийн 47.5 хувь нь Төвийн бүсэд, 21.7 хувь нь Баруун бүсэд, 19.9 хувь нь Хангайн бүсэд, 5.9 хувь нь Зүүн бүсэд үлдсэн 5.0 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Хоршооны ахлагч, гишүүдийн 92.5 хувь нь Төвийн бүсэд, 6.7 хувь нь Баруун бүсэд, 0.8 хувь нь Хангайн бүсэд ногдож байна.

Хүснэгт 11. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал, бүсээр

Бүс	БҮГД	Нөхөрлөлийн ахлагч болон гишүүн	Хоршооны ахлагч болон гишүүн	Хувиараа (дангаараа) ашигт малтмал олборлогч	Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч	Гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч
БҮГД	9 596	2 024	120	4 581	1 893	978
Баруун	3 597	439	8	2 262	312	576
Хангайн	1 300	402	1	672	93	132
Төвийн	3 312	961	111	1 504	517	219
Зүүн	171	120	-	45	3	3
Улаанбаатар	1 216	102	-	98	968	48

Хувиараа (дангаараа) ашигт малтмал олборлогчид 4581 байгаагийн 49.4 хувь нь Баруун бүсэд, 32.8 хувь нь Төвийн бүсэд, 14.7 хувь нь Хангайн бүсэд, 2.1 хувь нь Улаанбаатар хотод, 1.0 хувь нь Зүүн бүсэд ногдож байна.

Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгчид 1893 байгаагийн 51.1 хувь нь Улаанбаатар хотод, 27.3 хувь нь Төвийн бүсэд, 16.5 хувь нь Баруун бүсэд, 4.9 хувь нь Хангайн бүсэд, 0.2 хувь нь Зүүн бүсэд ногдож байна.


Гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогчид 978 байгаагийн 58.9 хувь нь Баруун бүсэд, 22.4 хувь нь Төвийн бүсэд, 13.5 хувь нь Хангайн бүсэд, 4.9 хувь нь Улаанбаатар хотод, 0.3 хувь нь Зүүн бүсэд тус тус ногдож байна.

Хүснэгт 12. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал, үйл ажиллагаанд оролцож буй үүргээр

Оролцож буй үүрэг	БҮГД	Нөхөрлөлийн ахлагч, гишүүн	Хоршооны ахлагч, гишүүн	Хувиараа (дангаараа) ашигт малтмал олборлогч	Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч	Гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч
БҮГД	9 596	2 024	120	4 581	1 893	978
Ашигт малтмал олборлох	5 295	1 219	14	3 926	121	15
Бичил уурхайн туслах ажил гүйцэтгэх	1 653	508	99	232	802	12
Ашигт малтмал худалдан авах	187	28	-	37	107	15
Хүнс, барааны худалдаа эрхлэх	182	22	-	38	106	16
Хоолны газар ажиллуулах	279	32	2	39	189	17
Тээврийн үйлчилгээ эрхлэх	498	41	2	47	380	28
Гэр бүлийн бизнест цалин хөлсгүй ажиллах	1 435	152	3	251	166	863
Хөрөнгө оруулах	67	22	-	11	22	12

Нийт бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 5.3 мянга буюу 55.2 хувь нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд, 1.7 мянга буюу 17.2 хувь нь бичил уурхайн туслах ажил гүйцэтгэх, 1.4 мянга буюу 15.0 хувь нь гэр бүлийн бизнест цалин хөлсгүй ажиллах, 0.5 мянга буюу 5.2 хувь нь тээврийн үйлчилгээ эрхлэх, 0.3 мянга буюу 2.9 хувь нь хоолны газар ажиллуулах, 0.2 мянга буюу 1.9 хувь нь ашигт малтмал худалдан авах, 0.2 мянга буюу 1.9 хувь нь барааны худалдаа эрхлэх үйл ажиллагаанд, 0.7 хувь нь хөрөнгө оруулах үйл ажиллагаанд тус тус оролцож байна.

Зураг 9. Нөхөрлөлийн ахлагч, гишүүдийн тоо, аймаг, нийслэл, төрлөөр




Нөхөрлөлийн ахлагч, гишүүн: Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчдын 0.5 мянга буюу 5.2 хувь нь нөхөрлөлийн ахлагч/ажил олгогч, 1.5 мянга буюу 15.9 хувь нь нөхөрлөлийн гишүүн байна. Харин нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон иргэдийн 24.6 хувь нь нөхөрлөлийн ахлагч/ажил олгогч, 75.4 хувь нь нөхөрлөлийн гишүүд байна.

Нөхөрлөлийн ахлагч, гишүүдийн тоо өмнөх судалгааны дүнгээс 94 иргэнээр буюу 4.9 хувиар нэмэгдсэн байна. Нөхөрлөлийн ахлагч, гишүүдийн 1.5 мянга буюу 74.5 хувь нь эрэгтэй, 0.5 мянга буюу 25.5 хувь нь эмэгтэй иргэд байгаа нь өмнөх судалгааны дүнгээс эрэгтэй иргэдийн эзлэх хувь 1.8 пунктээр буурч, эмэгтэй иргэдийн эзлэх хувь 1.8 пунктээр өссөн байна.

Хүснэгт 13. Нөхөрлөлийн ахлагч, гишүүдийн тоо, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг	БҮГД		Эрэгтэй		Эмэгтэй	
	2012	2016	2012	2016	2012	2016
БҮГД	1 930	2 024	1 471	1 507	459	517
15-17	11	2	11	2	-	-
18-19	40	24	30	21	10	3
20-24	256	142	228	127	28	15
25-29	324	259	274	216	50	43
30-34	338	305	266	248	72	57
35-39	327	303	240	218	87	85
40-44	250	359	168	249	82	110
45-49	196	301	134	205	62	96
50-54	116	194	72	134	44	60
55-59	54	88	35	53	19	35
60-64	9	30	6	21	3	9
65-69	7	13	5	9	2	4
70 +	2	4	2	4	-	-

Нөхөрлөлийн ахлагч, гишүүдийн тоог насны бүлгээр авч үзвэл, 15-39 хүртэлх насны иргэдийн тоо буурч, 40-өөс дээш насны иргэдийн тоо өссөн байна. Үүнээс үзэхэд ахимаг насны иргэд нөхөрлөлийн зохион байгуулалтад орж ажиллахыг илүүд үзэж байгаа нь харагдаж байна.



Зураг 10. Нөхөрлөлийн ахлагч, гишүүдийн тоо, орлого хуваарилалтын төрлөөр

Нөхөрлөлийн орлого хуваарилалтын байдлыг авч үзвэл, 872 буюу 43.1 нь бичил уурхайгаас олсон орлогоо гишүүддээ тэнцүү хуваарилдаг, 776 буюу 38.3 хувь нь хийснээр нь хуваарилдаг, 234 буюу 11.6 хувь нь тогтмол цалинждаг, 109 буюу 5.4 хувь нь орлого хуваарилдаггүй, 33 буюу 1.6 хувь нь орлогоо тогтмол хувь хэмжээгээр хуваарилдаг байна. Мөн нөхөрлөлийн ахлагч, гишүүдийн 73.4 хувь нь төрийн бус байгууллагад харьяалагдаж байна.

Нөхөрлөлийн орлого хуваарилалтыг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад орлогоо гишүүддээ тэнцүү хуваарилдаг нөхөрлөлд харьяалагддаг иргэдийн эзлэх хувь 4.4 пунктээр, орлогоо хийснээр нь хуваарилдаг нөхөрлөлд харьяалагддаг иргэдийн эзлэх хувь 1.6 пунктээр өссөн, орлого хуваарилдаггүй нөхөрлөлд харьяалагддаг иргэдийн эзлэх хувь 19.2 пунктээр буурсан байна.

Хүснэгт 14. Нөхөрлөлийн ахлагч, гишүүдийн тоо, орлого хуваарилалтын төрөл, бүсээр

Бүс	БҮГД	Орлогоо тэнцүү хуваарилдаг	Орлогоо хийснээр нь хуваарилдаг	Орлогоо тогтмол хувь хэмжээгээр хуваарилдаг	Тогтмол цалинждаг	Бусад
БҮГД	2 024	872	776	33	234	109
Баруун	439	361	56	1	2	19
Хангайн	402	94	167	11	117	13
Төвийн	961	404	356	16	114	71
Зүүн	120	7	106	5	1	1
Улаанбаатар	102	6	91	-	-	5

Нөхөрлөлийн орлого хуваарилалтыг бүсээр авч үзвэл, Төвийн бүсийн 46.3 хувь нь, Баруун бүсийн 41.4 хувь нь, Хангайн бүсийн 10.8 хувь нь бичил уурхайгаас олсон орлогоо гишүүддээ тэнцүү хуваарилдаг байна.

Хувиараа (дангаараа) ашигт малтмал олборлогч: Бичил уурхай эрхлэгчдийн 4.6 мянга буюу 47.7 хувь нь хувиараа (дангаараа) ашигт малтмал олборлогч байгаагийн 4.0 мянга буюу 86.3 хувь нь эрэгтэй, 0.6 буюу 13.7 хувь нь эмэгтэй байна.

Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч болон гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч: Нийт 1.9 мянган бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч судалгаанд хамрагдсаны 76.7 хувь нь эрэгтэй, 23.3 хувь нь эмэгтэй, 81.9 хувь нь бүрэн дундаас доош боловсролтой, 18.1 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролоос дээш мэргэжилтэй иргэд байна.

Харин гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогчдын 1.0 мянган иргэдийн 0.7 мянга буюу 67.3 хувь нь эмэгтэй, 84.9 хувь нь бүрэн дундаас доош боловсролтой байна.


3.2 БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ХУГАЦАА, ШАЛТГААН

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 1.4 мянга буюу 19.5 хувь нь нэг хүртэлх жил, 2.0 мянга буюу 28.7 хувь нь 2-3 жил, 1.4 мянга буюу 19.4 хувь нь 4-5 жил, 0.6 мянга буюу 8.8 хувь нь 6-7 жил, 0.4 мянга буюу 5.2 хувь нь 8-9 жил, 0.6 мянга буюу 9.2 хувь нь 10-11 жил, 0.6 мянга буюу 9.2 хувь нь 12 ба түүнээс дээш жил ажилласан байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн дийлэнх нь буюу 3.3 мянга буюу 48.2 хувь нь 3 хүртэлх жил ажилласан байгаа нь сүүлийн 3 жил иргэд бичил уурхайн салбарт шинээр татагдан орж байгааг илэрхийлж байна.


Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ажилласан жилийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 1 хүртэлх жил ажилласан иргэдийн эзлэх хувь 2.5 пунктээр, 2-3 жил ажилласан иргэдийнх 3.1 пунктээр, 8-9 жил ажилласан иргэдийнх 0.4 пунктээр буурч, 4-5 жил ажилласан иргэдийнх 0.2 пунктээр, 10-11 жил ажилласан иргэдийнх 2.2 пунктээр, 12-оос дээш жил ажилласан иргэдийнх 3.6 пунктээр өссөн байна.

Зураг 11. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид, бичил уурхайд ажилласан жилийн бүлэг, хувиар



Машин, механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч мэргэжилтэй 1 хүртэлх жил ажилласан 158, 2-3 жил ажилласан 197, 4-5 жил ажилласан 187, 6-7 жил ажилласан 121, 8-9 жил ажилласан 64, 10-11 жил ажилласан 144, 12 ба түүнээс дээш жил ажилласан 125 бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч байна.

Зураг 12. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид, хувиар, бичил уурхай эрхэлж буй шалтгаанаар



Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийг ямар шалтгаанаар уг үйл ажиллагааг эрхэлж байгааг судалж үзэхэд, 40.2 хувь нь байнгын ажлын байр олдоогүйгээс, 36.8 хувь нь нэмэлт орлого олох зорилгоор, 6.2 хувь нь малгүй болсон учраас, 16.9 хувь нь өөрийн бизнесээ болгох болон бусад зорилгоор бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байна.

Дээрх шалтгааныг бүсээр авч үзвэл, Баруун бүсийн бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 39.3 хувь нь байнгын ажлын байр олдоогүйгээс, 38.4 хувь нь нэмэлт орлого олох зорилгоор, 15.2 хувь нь бусад шалтгаанаар, 7.1 хувь нь малгүй болсон тул бичил уурхайн үйл ажиллагааг эрхэлсэн гэж хариулжээ.

Хүснэгт 15. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид, бичил уурхай эрхэлж буй шалтгаанаар, давхардсан тоогоор

Бүс	БҮГД	Байнгын ажлын байр олдоогүй	Малгүй болсон	Нэмэлт орлого олох зорилгоор	Бусад
БҮГД	9 589	3 851	595	3 526	1 617
Баруун	3 630	1 428	257	1 395	550
Хангайн	1 419	526	130	527	236
Төвийн	3 416	1 310	178	1 362	566
Зүүн	199	83	10	82	24
Улаанбаатар	925	504	20	160	241

Харин Төвийн бүсийн хувьд 39.9 хувь нь нэмэлт орлого олох зорилгоор, 38.3 хувь нь байнгын ажлын байр олдоогүйгээс, 16.6 хувь нь бусад шалтгаанаар, 5.2 хувь нь малгүй болсон шалтгаанаар бичил уурхайн үйл ажиллагааг эрхэлж байна.

Улаанбаатар хотын хувьд 54.5 хувь нь байнгын ажлын байр олдоогүйгээс, 26.1 хувь нь бусад шалтгаанаар, 17.3 хувь нь нэмэлт орлого олох зорилгоор, 2.2 хувь нь малгүй болсон шалтгаанаар бичил уурхайн үйл ажиллагааг эрхэлж байна.

3.3 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУУЦ, ЦАХИЛГААН ХАНГАМЖ, УНДНЫ УС

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаагаа эрхлэх хугацаанд амьдарч буй сууцны төрөл, сууцны эзэмшил, ундны усны эх үүсвэр, цахилгааны эх үүсвэрийн талаар энэхүү хэсэгт авч үзэх бөгөөд бичил уурхайн үйл ажиллагаанд туслах үйл ажиллагаа эрхлэгч, гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогчдын талаарх мэдээлэл энд ороогүй болно.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн сууцны төрөл: Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 3.1 мянга буюу 51.8 хувь нь үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа орд газарт байрлаж ямар нэгэн хэлбэрийн сууцанд амьдардаг гэж хариулсан бол үлдсэн 2.9 мянга буюу 48.2 хувь нь ямар нэгэн сууцанд амьдардаггүй гэж хариулсан байна.

Зураг 13. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн сууцны төрөл, эзэмшлийн хэлбэрээр



Сууцанд амьдардаг гэж хариулсан хүмүүсийн 44.3 хувь нь гэрт, 36.7 хувь нь майханд, 8.3 хувь нь түр оромжид, 8.1 хувь нь бусад хэлбэрийн сууцанд, 2.1 хувь нь байшинд, 0.5 хувь нь нүхэн сууцанд амьдардаг байна. Үүнээс харахад сууцанд амьдардаг хүмүүсийн 50 гаруй хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байна.

Сууцны төрлийг эзэмшлийн төрлөөр нь авч үзвэл, 1496 хүн буюу 48.2 хувь нь өөрийн эзэмшлийн, 1511 хүн буюу 48.6 хувь нь хамтын эзэмшлийн, харин 99 хүн буюу 3.2 хувь нь түрээсийн сууцанд амьдардаг байна. Үүнээс гэрт суудаг 1377 бичил уурхай эрхлэгчдийн 38.8 хувь нь өөрийн эзэмшлийн, 55.8 хувь нь хамтын эзэмшлийн, 5.4 хувь нь түрээсийн гэрт амьдардаг бол майханд амьдардаг 1141 хүний 65.1 хувь нь өөрийн эзэмшлийн, 33.8 хувь нь хамтын эзэмшлийн, 1.1 хувь нь түрээсийн майханд амьдардаг байна.

Өөрийн эзэмшлийн сууцны 35.7 хувь нь гэр, 2.1 хувь нь байшин, 49.7 хувь нь майхан, 3.4 хувь нь түр оромж, 0.1 хувь нь нүхэн сууц, 9.0 хувь нь бусад хэлбэрийнх байгаа бол хамтын эзэмшлийн сууцны 50.8 хувь нь гэр, 1.9 хувь нь байшин, 25.5 хувь нь майхан, 13.5 хувь нь түр оромж, 0.9 хувь нь нүхэн сууц, 7.3 хувь нь бусад хэлбэрийнх байна. Харин түрээсийн сууцны 75.8 хувь нь гэр, 4.0 хувь нь байшин, 12.1 хувь нь майхан, 2.0 хувь нь түр оромж, 6.1 хувь нь бусад хэлбэрийнх байна.

Хүснэгт 16. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн сууцны төрөл, бүсээр


Бүс	БҮГД	Гэр	Байшин	Майхан	Түр оромж	Нүхэн сууц	Бусад
БҮГД	3 106	1 377	64	1 141	257	16	251
Баруун	1 303	515	17	625	83	12	51
Хангайн	527	364	7	106	18	-	32
Төвийн	1 132	399	32	378	154	3	166
Зүүн	107	71	2	32	1	1	
Улаанбаатар	37	28	6	-	1	-	2

Бичил уурхай олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн цахилгааны эх үүсвэр: Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж байгаа газрынх нь цахилгааны эх үүсвэрийг энд тодорхойлсон. Цахилгааны эх үүсвэр нь бичил уурхай эрхлэгчдийн ая тухтай ажиллаж, амьдрах нэг чухал үзүүлэлт бөгөөд үүнтэй холбоотойгоор бичил уурхайчдын үйл ажиллагаа явуулж буй газрынх нь цахилгааны эх үүсвэрийн мэдээллийг төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, бага оврын цахилгаан үүсгүүр, цахилгааны эх үүсвэргүй гэж ангилан судаллаа.

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн талаас илүү нь буюу 53.6 хувь нь цахилгааны ямар нэгэн эх үүсвэргүй газар бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байна.

Цахилгааны эх үүсвэртэй нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчдын 54.8 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүр ашиглан цахилгаан хэрэглэдэг бол 36.3 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашиглан цахилгаанд холбогддог байна. Харин 5.0 хувь нь төвлөрсөн системээс цахилгаан хэрэглэж, үлдсэн 3.9 хувь нь дизель станцтай холбогдсон байна.

Зураг 14. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн цахилгааны эх үүсвэр, төрөл, хувиар



Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн цахилгааны эх үүсвэрийг ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл жонш олборлогчдын 16.6 хувь, нүүрс олборлогчдын 46.9 хувь, үнэт чулууны бичил уурхай эрхлэгчдийн 52.6 хувь, гянтболд олборлогчдын 54.0 хувь, алт олборлогчдын 57.2 хувь нь цахилгааны эх үүсвэргүй газар амьдарч байна.

Үнэт чулуу олборлогчдын 47.4 хувь нь, гянтболд олборлогчдын 28.0 хувь нь, алт олборлогчдын 27.0 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүр ашиглаж байгаа бол нүүрс олборлогчдын 53.1 хувь нь төвлөрсөн системд холбогдсон цахилгаан хэрэглэж байна.

Жонш олборлогчдын 59.4 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашиглан цахилгаанд холбогддог байна.

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн цахилгааны эх үүсвэрийг бүсийн түвшинд авч үзвэл, Баруун бүсийн бичил уурхай эрхлэгчдийн 68.5 хувь нь, Хангайн бүсийн бичил уурхай эрхлэгчдийн 30.9 хувь нь, Төвийн бүсийн бичил уурхай эрхлэгчдийн 48.0 хувь нь, Зүүн бүсийн бичил уурхай эрхлэгчдийн 59.8 хувь нь ямар нэгэн цахилгааны эх үүсвэргүй газар амьдарч байна.

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн үндны усны эх үүсвэр: Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж байгаа газрын үндны усны эх үүсвэрийг энд тодорхойлсон.

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 2197 хүн буюу 36.6 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шандаас үндны усаа хангаж байна.

Харин 3150 бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгч буюу 52.5 хувь нь зөөврийн усаар үндны усны хэрэгцээгээ хангадаг бол 314 бичил уурхай эрхлэгч буюу 5.2 хувь нь хамгаалагдсан худгийн усаар үндны эх үүсвэрээ хангадаг гэж хариулжээ. Үлдсэн 5.7 хувь нь хамгаалагдсан булаг, шанд, цэвэршүүлэн савласан ус зэрэг эх үүсвэрээс үндны усны хэрэгцээгээ хангадаг байна.

Үндны усны бусад эх үүсвэрээс хэрэгцээгээ хангадаг иргэдийн 107 хүн буюу 1.8 хувь нь хамгаалагдсан булаг, шандын ус, 151 хүн буюу 2.5 хувь нь цэвэршүүлэн савласан ус, 65 хүн буюу 1.1 хувь нь төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байрны ус, 14 хүн буюу 0.2 хувь нь төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байрнаас үндны усаа авч хэрэглэдэг байна.

Хүснэгт 17. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн үндны усны эх үүсвэр, хувиар, бүсээр

Бүс	БҮГД	Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр	Хамгаалагдсан худаг	Хамгаалагдсан булаг, шанд	Цэвэршүүлэн савласан ус	Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр	Зөөврийн ус	Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд
БҮГД	100.0	1.1	5.2	1.8	2.5	0.2	52.5	36.6
Баруун	100.0	0.5	2.7	2.4	0.1	0.2	57.6	36.6
Хангайн	100.0	0.9	15.1	2.6	0.4	0.1	40.4	40.5
Төвийн	100.0	1.7	3.7	1.0	6.4	0.4	48.1	38.7
Зүүн	100.0	4.3	14.0	0.6	0.6	-	55.5	25.0
Улаанбаатар	100.0	0.6	-	-	0.6	0.6	98.2	-

Үндны эх үүсвэрийг бүсээр авч үзвэл зөөврийн усаар үндны хэрэгцээгээ Улаанбаатар хотын иргэдийн 98.2 хувь, Баруун бүсийн иргэдийн 57.6 хувь, Зүүн бүсийн иргэдийн 55.5 хувь, Төвийн бүсийн иргэдийн 48.1 хувь, Хангайн бүсийн иргэдийн 40.4 хувь нь хангаж байна. Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шандын усаар Хангайн бүсийн иргэдийн 40.5 хувь, Төвийн бүсийн иргэдийн 38.7 хувь, Баруун бүсийн иргэдийн 36.6 хувь, Зүүн бүсийн иргэдийн 25.0 хувь нь үндны усны хэрэгцээгээ хангаж байна.

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн үндны усны эх үүсвэрийг ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл, алт олборлогчдын 50.2 хувь нь зөөврийн уснаас, 39.8 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шандаас, үлдсэн 10 хувь нь бусад эх үүсвэрээс (хамгаалагдсан худаг, хамгаалагдсан булаг, шанд, цэвэршүүлэн савласан ус, төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр, төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр) үндны усны хэрэгцээгээ хангаж байна.

Хүснэгт 18. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн үндны усны эх үүсвэр, хувиар, олборлодог ашигт малтмалын төрөл

Бүс	БҮГД	Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр	Хамгаалагдсан худаг	Хамгаалагдсан булаг, шанд	Цэвэршүүлэн савласан ус	Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр	Зөөврийн ус	Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд
БҮГД	100.0	1.1	5.2	1.8	2.5	0.2	52.5	36.6
Алт	100.0	1.0	5.6	2.1	1.1	0.2	50.2	39.8
Нүүрс	100.0	0.7	-	-	0.7	0.7	82.8	14.9
Жонш	100.0	1.7	3.4	0.3	14.0	0.1	78.3	2.2
Гянтболд	100.0	1.3	-	3.2	-	-	14.6	80.9
Шохойн чулуу	100.0	-	53.3	-	-	-	46.7	-
Үнэт чулуу	100.0	-	-	-	-	-	20.5	79.5
Бусад	100.0	-	11.3	-	-	1.0	19.6	68.0

Харин нүүрс олборлогчдын 82.8 хувь нь зөөврийн усаар, 14.9 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шандын усаар үндны усны хэрэгцээгээ хангадаг бол жонш олборлогчдын 78.3 хувь нь зөөврийн усаар, 14.0 хувь нь цэвэршүүлэн савласан усаар үндны усны хэрэгцээгээ хангаж шохойн чулуу олборлогчдын 53.3 хувь нь хамгаалагдсан худгийн усаар, 46.7 хувь нь зөөврийн усаар үндны усны хэрэгцээгээ хангадаг байна.

4

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй 18-аас доош насны 188 хүүхдийн 61.8 хувь нь сургуулийн амралтаараа ажилладаг бөгөөд ус, чулуу, шороо зөөх ажилд хамгийн их оролцож байна.


БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ

Энэ бүлэгт бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдүүдийн эрх ашиг, бэртэл гэмтэл, бичил уурхайд гүйцэтгэж буй үүргийн талаар судалсан.

4.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ

2012 оны судалгааны дүнгээр нийт 13375 иргэн бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байсны 928 нь буюу 7.0 хувь нь 10-18 насныхан байсан байна. Харин 2016 оны судалгаагаар нийт 9596 иргэн бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаагийн 188 нь буюу 2.0 хувь 10-18 насныхан байна.

Зураг 15. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй хүүхдийн тоо



Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогч иргэдийн хүүхдийн эрхийн талаарх мэдлэгийн түвшнийг авч үзвэл, 2408 иргэн буюу 34.7 хувь нь сайн, 3395 иргэн буюу 48.9 хувь нь дунд, 645 иргэн буюу 9.3 хувь нь муу, 500 иргэн буюу 7.2 хувь нь огт мэдэхгүй гэж хариулсан байна.

Хүснэгт 19. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хүүхдийн эрхийн талаарх мэдлэгийн түвшин, бүсээр


Бүс	БҮГД	Сайн	Дунд	Муу	Мэдэхгүй
БҮГД	6 948	2 408	3 395	645	500
Баруун	2 614	880	1 264	283	187
Хангайн	963	310	437	115	101
Төвийн	2 440	864	1 173	213	190
Зүүн	164	62	84	9	9
Улаанбаатар	767	292	437	25	13

Хүүхдийн эрхийн талаарх мэдлэгийн түвшнийг бүсээр авч үзвэл, Улаанбаатар хотын иргэдийн 38.1 хувь, Зүүн бүсийн иргэдийн 37.8 хувь, Төвийн бүсийн иргэдийн 35.4 хувь, Баруун бүсийн иргэдийн 33.7 хувь, Хангайн бүсийн иргэдийн 32.2 хувь нь сайн мэдлэгтэй гэж хариулсан байна. Харин Улаанбаатар хотын иргэдийн 57.0 хувь, Зүүн бүсийн иргэдийн 51.2 хувь, Баруун бүсийн иргэдийн 48.4 хувь, Төвийн бүсийн иргэдийн 48.1 хувь, Хангайн бүсийн иргэдийн 45.4 хувь нь дунд зэргийн мэдлэгтэй гэж хариулсан байна.

4.2 БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 18-ААС ДООШ НАСНЫ ХҮҮХДИЙН ОРОЛЦОО

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй хүүхдүүдийн 61.8 хувь нь улирлын амралтаараа, 34.2 хувь нь хичээлийн бус цагаараа, 2.6 хувь нь жилийн туршид бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байна.

Зураг 16. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй хүүхдийн тоо, хувиар, ажиллаж буй хугацааны төрлөөр



Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй 18-аас доош насны хүүхдүүдийн дийлэнх нь буюу 51.1 хувь нь ус, чулуу, шороо зөөх ажилд, 28.7 хувь нь нүх ухах ажилд, 8.5 хувь нь алт, чулуу угаах ажилд, 4.3 хувь нь чулуу бутлах ажилд, 7.4 хувь нь бусад туслах үйл ажиллагаанд оролцдог байна.

Хүснэгт 20. Бичил уурхайн үйл ажиллагаа дахь хүүхдийн оролцоо, хувиар, бүсээр

Бүс	БҮГД	Нүх ухах	Ус, чулуу шороо зөөх	Чулуу бутлах	Алт, чулуу угаах	Бусад
БҮГД	100.0	28.7	51.1	4.3	8.5	7.4
Баруун	100.0	34.8	47.0	4.5	6.1	7.6
Хангайн	100.0	-	61.5	-	30.8	7.7
Төвийн	100.0	26.7	60.0	6.7	-	6.7

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй хүүхдүүдийн оролцоог бүсээр авч үзвэл, Баруун бүсийн хүүхдүүдийн 47.0 хувь нь ус, чулуу, шороо зөөх ажилд, 34.8 хувь нь нүх ухах ажилд оролцож байгаа бол Хангайн бүсийн хүүхдүүдийн 61.5 хувь нь ус, чулуу, шороо зөөх ажилд, 30.8 хувь нь алт, чулуу угаах ажилд оролцож байна. Харин Төвийн бүсийн хүүхдүүдийн 60.0 хувь нь ус, чулуу, шороо зөөх ажилд, 26.7 хувь нь нүх ухах ажилд оролцдог байна.

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож байгаа хүүхдүүдийн 66.7 хувь хөнгөн бэртэл, 23.1 хувь нь тулах эрхтний гэмтэл, 5.1 хувь нь тархи, нуруу, нугасны гэмтэл, 5.2 хувь нь хараа, сонсголын эрхтний гэмтэл болон хорт бодист хордсон байна.

Хүснэгт 21. Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй хүүхдийн тоо, хувиар, бүс, бэртэл гэмтлийн төрлөөр

Бүс	БҮГД	Хөнгөн гэмтэл	Тулах эрхтний гэмтэл	Хараа, сонсголын эрхтний гэмтэл	Тархи, нуруу, нугасны гэмтэл	Хорт бодист хордох
Бүгд	100.0	66.7	23.1	2.6	5.1	2.6
Баруун	100.0	64.3	21.4	7.1	7.1	-
Хангайн	100.0	50.0	50.0	-	-	-
Төвийн	100.0	71.4	19.0	-	4.8	4.8

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй хүүхдүүдийн бэртэл гэмтлийг бүсээр авч үзвэл Баруун бүсийн хүүхдүүдийн 64.3 хувь нь хөнгөн гэмтэл, 21.4 хувь нь тулах эрхтний гэмтэл, 14.2 хувь нь хараа, сонсголын эрхтний гэмтэл болон тархи, нуруу, нугасны гэмтэл авсан бол Хангайн бүсийн хүүхдүүдийн 50.0 хувь нь хөнгөн гэмтэл, 50.0 хувь нь тулах эрхтний гэмтэл, Төвийн бүсийн хүүхдүүдийн 71.4 хувь нь хөнгөн гэмтэл, 19.0 хувь нь тулах эрхтний гэмтэл, 9.6 хувь нь тархи, нуруу, нугасны гэмтэл болон хорт бодист хордсон байна.

5

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЦЭЭ, МЭДЭЭЛЭЛ АВАХ СУВАГ


Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгаанд хамрагдсан иргэдэд нийгмийн халамж, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаарх мэдээлэл хамгийн их хэрэгцээтэй байна.

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЦЭЭ, МЭДЭЭЛЭЛ АВАХ СУВАГ

5.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 93.2 хувь нь буюу 6474 иргэн гар утас ашиглаж байна. Үүний 74.4 хувь буюу 4818 иргэн энгийн утас, 25.6 хувь нь буюу 1656 иргэн ухаалаг утас ашиглаж байна.

Зураг 17. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн гар утасны хэрэглээ, утасны төрлөөр



Гар утас хэрэглэдэг бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 87.2 хувь нь буюу 5643 эрэгтэй, 12.8 хувь нь буюу 831 эмэгтэй иргэд байна. Гар утас хэрэглэдэг эрэгтэй бичил уурхай эрхлэгчдийн 75.2 хувь энгийн, 24.8 хувь нь ухаалаг утас хэрэглэдэг бол эмэгтэй бичил уурхай эрхлэгчдийн 69.2 хувь нь энгийн, 30.8 хувь нь ухаалаг утас ашигладаг байна.

Хүснэгт 22. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн гар утасны хэрэглээ, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг	БҮГД			Энгийн			Ухаалаг		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	6474	5643	831	4818	4243	575	1656	1400	256
10-14	1	1	-	1	1	-	-	-	-
15-17	13	13	-	5	5	-	8	8	-
18-19	81	73	8	41	35	6	40	38	2
20-24	465	431	34	260	240	20	205	191	14
25-29	980	898	82	619	575	44	361	323	38
30-34	1107	1009	98	764	707	57	343	302	41
35-39	1054	906	148	787	684	103	267	222	45
40-44	1002	858	144	803	711	92	199	147	52
45-49	809	679	130	684	582	102	125	97	28
50-54	577	472	105	505	424	81	72	48	24
55-59	269	205	64	244	189	55	25	16	9
60-64	88	73	15	79	67	12	9	6	3
65-69	23	20	3	22	19	3	1	1	-
70+	5	5	-	4	4	-	1	1	-


Насны бүлгээр авч үзвэл, гар утас хэрэглэдэг эрэгтэй бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 17.9 хувийг 30-34 насныхан, 16.1 хувийг 35-39 насныхан, 15.9 хувийг 25-29 насныхан эзэлж байгаа бол эмэгтэй бичил уурхай эрхлэгчдийн хувьд 17.8 хувийг 35-39 насныхан, 17.3 хувийг 40-44 насныхан, 15.6 хувийг 45-49 насныхан эзэлж байна.

5.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд хууль эрх зүй, дүрэм журам болон өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хомсдолтойгоос үүдэн өөрсдийгөө болон байгаль орчноо хохироох тохиолдол нэлээдгүй гардаг.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэдэд хамгийн их хэрэгцээтэй мэдээллийг төрлөөр авч үзвэл, давхардсан тоогоор 23.2 хувь нь нийгмийн халамж, эрүүл мэнд, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны талаар, 19.2 хувь нь бичил уурхайн талаар, 17.1 хувь нь өдөр тутмын мэдээллийн талаар, 14.7 хувь нь хууль эрх зүйн, 11.4 хувь нөхөн сэргээлт, байгаль орчны талаарх мэдээлэл байгаа бол үлдсэн 14.4 хувь нь бусад (үлс төр, боловсрол, соёл, шинжлэх ухаан, гэр бүл хүүхдийн асуудал гэх мэт) төрлийн мэдээлэл гэж хариулжээ.

Зураг 18. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хамгийн их хэрэгцээтэй мэдээллийн төрөл, хувиар, давхардсан тоогоор



Судалгааны дүнгээс харахад бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдэд бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, хууль эрх зүйн орчин, дүрэм журам болон байгаль орчны асуудлын талаарх мэдээлэл түлхүү хэрэгцээтэй байна.

Судалгаанд хамрагдсан нийт бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдээллийн эх үүсвэрийг авч үзэхэд 42.5 хувийг телевизээс, 16.0 хувийг бусад иргэдээс, 10.5 хувийг хурал, цуглаанаас, 8.9 хувийг гар утсаараа дамжуулан, 7.5 хувийг интернет, нийгмийн сүлжээнээс, 6.2 хувийг сонин, сэтгүүлээс, 3.8 хувийг радиогоос, 2.5 хувийг хэвлэмэл тараах материалаас, 2.0 хувийг мэдээллийн самбараас, 0.2 хувийг бусад эх үүсвэрээс авдаг байна.

Хүснэгт 23. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдээллийн эх үүсвэр, бүсээр, давхардсан тоогоор

Бүс	БҮГД	Телевизээс	Радиогоос	Интернет, нийгмийн сүлжээнээс	Гар утсаараа дамжуулан	Бусад иргэдээс	Мэдээллийн самбараас	Сонин, сэтгүүлээс	Хэвлэмэл тараах материалаас	Хурал, цуглаанаас	Бусад
БҮГД	100.0	42.5	3.8	7.5	8.9	16.0	2.0	6.2	2.5	10.5	0.2
Баруун	100.0	42.3	5.4	4.1	7.4	17.5	2.1	5.6	2.6	12.7	0.1
Хангайн	100.0	48.1	1.6	6.6	7.9	14.6	1.5	5.7	1.2	12.8	-
Төвийн	100.0	39.0	3.1	9.8	11.4	15.2	1.4	6.6	3.0	10.1	0.3
Зүүн	100.0	31.7	3.3	8.3	3.3	16.4	8.1	18.8	2.6	7.1	0.2
Улаанбаатар	100.0	53.5	2.7	11.7	7.9	14.5	3.1	3.4	1.7	1.4	0.1

Мэдээллийн эх үүсвэрийг бүсээр авч үзвэл, бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хамгийн гол мэдээллийн эх үүсвэр нь бүх бүсийн хувьд телевиз байна. Бусад мэдээллийн эх үүсвэрийн хувьд Баруун бүс, Хангайн бүс болон Төвийн бүсийн бичил уурхай эрхлэгчид нь мэдээллийг бусад иргэд болон хурал цуглаанаас авдаг гэж хариулсан бол Зүүн бүсийн бичил уурхай эрхлэгчид сонин, сэтгүүлээс ихэвчлэн мэдээллээ авдаг гэж хариулжээ. Харин Улаанбаатар хотын бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид бусад иргэд болон интернет, нийгмийн сүлжээнээс мэдээллийг авдаг гэж хариулсан байна.

Хүснэгт 24. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдээлэл олж авдаг мэдээллийн эх үүсвэр, хувиар, насны бүлэг, давхардсан тоогоор

Насны бүлэг	Телевизээс	Радиоогоос	Интернет, нийгмийн сүлжээ	Гар утсаараа дамжуулан	Бусад иргэдээс	Мэдээллийн самбараас	Сонин, сэтгүүлээс	Хэвлэмэл тараах материал	Хурал, цуглаанаас	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
11-14	-	-	0.1	-	-	-	-	-	-	-
15-17	0.2	0.2	0.2	0.2	0.3	0.3	0.1	0.3	-	-
18-19	1.2	0.5	2.6	1.4	1.0	1.3	1.0	0.8	0.4	-
20-24	6.8	3.4	15.1	8.9	5.7	6.9	5.0	8.0	5.3	-
25-29	14.9	12.0	24.9	17.3	12.7	14.2	11.4	15.2	13.0	4.3
30-34	16.8	12.9	19.1	18.6	16.9	13.5	14.1	16.0	16.2	21.7
35-39	16.6	17.0	13.3	17.0	16.9	14.5	15.2	14.6	16.1	8.7
40-44	15.5	15.7	11.1	14.3	16.8	17.2	17.0	16.0	17.1	13.0
45-49	12.5	16.4	7.7	11.5	13.7	16.2	15.5	14.6	14.8	17.4
50-54	9.1	10.5	4.4	7.4	9.9	10.6	11.6	10.6	10.9	17.4
55-59	4.3	8.0	0.9	2.4	4.4	3.6	6.0	2.9	4.3	8.7
60-64	1.4	2.7	0.4	0.9	1.5	1.7	2.5	0.8	1.1	8.7
65-69	0.4	0.7	0.2	0.2	0.3	-	0.5	0.3	0.4	-
70+	0.1	-	-	-	-	-	-	-	0.2	-

Насны бүлгээр нь авч үзвэл, телевиз болон гар утсаараа дамжуулан 30-34 насныхан, радио болон бусад иргэдээс 35-39 насныхан, интернет, нийгмийн сүлжээнээс 25-29 насныхан, мэдээллийн самбар, хэвлэмэл тараах материал, сонин, сэтгүүл болон хурал цуглаанаас 40-44 насныхан хамгийн их мэдээлэл олж авдаг байна.

Хүснэгт 25. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдээлэл олж авдаг мэдээллийн эх үүсвэр, хувиар, ашигт малтмалын төрөл, давхардсан тоогоор

Ашигт малтмалын төрөл	БҮГД	Телевизээс	Радиоогоос	Интернет, нийгмийн сүлжээнээс	Гар утсаараа дамжуулан	Бусад иргэдээс	Мэдээллийн самбараас	Сонин, сэтгүүлээс	Хэвлэмэл тараах материал	Хурал, цуглаанаас	Бусад
БҮГД	100.0	42.5	3.8	7.5	8.9	16.0	2.0	6.2	2.5	10.5	0.2
Алт	100.0	41.9	3.5	7.0	9.7	16.9	1.6	6.1	2.0	11.1	0.2
Нүүрс	100.0	54.9	3.1	11.0	8.6	15.1	3.4	1.8	1.0	1.1	0.0
Жонш	100.0	41.4	4.6	8.6	4.4	10.0	3.9	10.3	3.9	12.8	0.1
Гянтболд	100.0	38.7	5.2	3.3	7.6	15.4	0.5	5.9	9.5	13.3	0.5
Шохойн чулуу	100.0	31.0	28.6	0.0	14.3	21.4	0.0	2.4	2.4	0.0	0.0
Үнэт чулуу	100.0	34.3	0.0	14.6	14.6	10.2	2.9	2.2	5.8	15.3	0.0
Элс, хайрга	100.0	33.3	0.0	4.8	4.8	14.3	0.0	14.3	19.0	9.5	0.0
Бусад	100.0	29.0	8.2	6.5	7.6	21.1	2.3	5.9	6.7	12.3	0.3



Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийг олборлож байгаа ашигт малтмалын төрлөөр нь мэдээллийн эх үүсвэрийг авч үзвэл:

Алт олборлож байгаа иргэдийн 41.9 хувь нь телевизээс, 16.9 хувь нь бусад иргэдээс, 11.1 хувь нь хурал, цуглаанаас, 9.7 хувь нь гар утсаараа дамжуулан, 7.0 хувь нь интернет, нийгмийн сүлжээнээс, 6.1 хувь нь сонин сэтгүүлээс, 3.5 хувь нь радиогоос, 2.0 хувь нь хэвлэмэл тараах материалаас, 0.2 хувь нь бусад эх үүсвэрээс мэдээллээ авдаг байна.

Нүүрс олборлож байгаа иргэдийн 54.9 хувь нь телевизээс, 15.1 хувь нь бусад иргэдээс, 11.0 хувь нь интернет, нийгмийн сүлжээнээс, 8.6 хувь нь гар утсаараа дамжуулан, 3.4 хувь нь мэдээллийн самбараас, 3.1 хувь нь радиогоос, 1.8 хувь нь сонин, сэтгүүлээс, 1.1 хувь нь хурал, цуглаанаас, 1.0 хувь нь хэвлэмэл тараах материалаас мэдээллээ авдаг байна.

Жонш олборлож байгаа иргэдийн 41.4 хувь нь телевизээс, 12.8 хувь нь хурал, цуглаанаас, 10.3 хувь нь сонин, сэтгүүлээс, 10.0 хувь нь бусад иргэдээс, 8.6 хувь нь интернет, нийгмийн сүлжээнээс, 4.6 хувь нь радиогоос, 4.4 хувь нь гар утсаараа дамжуулан, 3.9 хувь нь мэдээллийн самбар болон хэвлэмэл тараах материалаас, 0.1 хувь нь бусад эх үүсвэрээс мэдээллээ авдаг байна.

Гянтболд олборлож байгаа иргэдийн 38.7 хувь нь телевизээс, 15.4 хувь нь бусад иргэдээс, 13.3 хувь нь хурал, цуглаанаас, 9.5 хувь нь хэвлэмэл тараах материалаас, 7.6 хувь нь гар утсаараа дамжуулан, 5.9 хувь нь сонин, сэтгүүлээс, 5.2 хувь нь радиогоос, 3.3 хувь нь интернет, нийгмийн сүлжээнээс, 1.0 хувь нь мэдээллийн самбар болон бусад эх үүсвэрээс мэдээллээ авдаг байна.

Шохойн чулуу олборлож байгаа иргэдийн 31.0 хувь нь телевизээс, 28.6 хувь нь радиогоос, 21.4 хувь нь бусад иргэдээс, 14.3 хувь нь гар утсаараа дамжуулан, 5.8 хувь нь сонин, сэтгүүл болон хурал, цуглаанаас мэдээллээ авдаг байна.

Үнэт чулуу олборлож байгаа иргэдийн 34.3 хувь нь телевизээс, 29.2 хувь нь интернет, нийгмийн сүлжээ болон гар утсаараа дамжуулан, 15.3 хувь нь хурал, цуглаанаас, 5.8 хувь нь хэвлэмэл тараах материалаас, 2.9 хувь нь мэдээллийн самбараас, 2.2 хувь нь сонин, сэтгүүлээс мэдээллээ авдаг байна.



6

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЗРҮҮЛ АХУЙН МЭДЛЭГ

Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгаанд хамрагдсан олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгч 5998 иргэдийн 2.0 хувь нь үйлдвэрлэлийн осол, аварга өртсөн байна.

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААРХ МЭДЛЭГ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс, мөн энэ талаарх мэдлэг багатайгаас үүдэн осол аваарт өртөх явдал тохиолддог. Тиймээс энэ бүлэгт бичил уурхай эрхлэгчдийн эрх зүйн орчин, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх мэдлэгийн түвшин, үйл ажиллагаа эрхлэх явцад өртөж байсан осол гэмтэл, тэдэнд учирсан хохирол, өвчилж байсан өвчний төрөл, эмнэлгийн тусламжийн хүртээмж зэргийг авч үзсэн.

6.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААРХ МЭДЛЭГ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх мэдлэгийн түвшнийг авч үзвэл, 19.5 хувь нь хангалттай мэдлэгтэй, 64.5 хувь нь зохих хэмжээний мэдлэгтэй, 16.0 хувь нь хангалтгүй мэдлэгтэй гэж өөрсдийгөө үнэлсэн байна. Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж буй бичил уурхай эрхлэгчдийн мэдлэгийн түвшин бусад бүсүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байна.


Хүснэгт 26. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх мэдлэг, хувиар, бүсээр

Бүс	БҮГД	Хангалттай	Боломжийн	Хангалтгүй
БҮГД	100.0	19.5	64.5	16.0
Баруун	100.0	13.9	67.4	18.6
Хангайн	100.0	19.4	60.6	19.9
Төвийн	100.0	23.0	61.4	15.6
Зүүн	100.0	23.2	59.1	17.7
Улаанбаатар	100.0	26.6	70.5	2.9

6.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛДВЭРИЙН ОСОЛ АВААР, ӨВЧНИЙ ТӨРӨЛ

Судалгааны дүнгээр судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 98.0 хувь нь үйл ажиллагаа эрхлэх явцдаа осол, аваарт өртөж байгаагүй гэж хариулсан байна. Харин үлдсэн 2.0 хувь нь ямар нэгэн осол, аваарт өртсөн байна. Осол, аваарт өртсөн иргэдийг ослын төрлөөр нь харвал давхардсан тоогоор 30.9 хувь нь шороонд дарагдах осолд, 28.2 хувь нь нүхэнд унах осолд, 19.5 хувь нь агааргүйдэх осолд, 13.4 хувь нь бусад төрлийн осолд, 6.0 хувь нь хөлдөх осолд, 2.0 хувь нь түлэгдэх осолд өртсөн байна.

Зураг 19. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн өртөж байсан осол, аваарын төрөл, хувиар




Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцдаа ямар нэгэн осол, аваарт өртөж байсан хүмүүсийг бүсийн түвшинд авч үзвэл агааргүйдэх осолд өртөгсдийн 34.1 хувь нь, шороонд дарагдах осолд өртөгсдийн 49.0 хувь нь, нүхэнд унах осолд өртөгсдийн 41.3 хувь нь тус бүр Төвийн бүсэд ногдож байгаа бол, хөлдөх осолд өртөгсдийн 44.4 хувь нь Хангайн бүсэд, угаартах осолд өртөгсдийн 36.4 хувь нь Баруун бүсэд, 36.4 хувь нь Төвийн бүсэд ногдож, харин бусад шалтгаанаар осолд өртөгсөд Баруун, Хангайн, Төвийн бүсүүдэд адил хувьтай байна. Нийт осолд өртөгсдийн дийлэнх хувь нь Төвийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхай эрхлэгчид байна.

Хүснэгт 27. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн өртөж байсан осол, аваарын төрөл, хувиар, бүсээр

Бүс	Агааргүйдэх	Шороонд дарагдах	Хөлдөх	Нүхэнд унах	Угаартах	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	12.2	26.5	22.2	32.6	36.4	33.3
Хангайн	24.4	16.3	44.4	19.6	9.1	33.3
Төвийн	34.1	49.0	33.3	41.3	36.4	33.3
Зүүн	-	4.1	-	4.3	-	-
Улаанбаатар	29.3	4.1	-	2.2	18.2	-


Уурхайн үйл ажиллагаанаас учирсан хохирлыг эрүүл мэндээр хохирсон, эд материалаар хохирсон гэж ангилан авч үзэв. Нийт хохирлын 88.7 хувь нь эрүүл мэндийн хохирол, 11.3 хувь нь эд материалын хохирол бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэн учирсан гэж хариулжээ. Эрүүл мэндийн хохирол амссан бичил уурхайчдын 28.0 хувь нь шороонд дарагдах ослоос, 26.2 хувь нь нүхэнд унах ослоос, 24.4 хувь нь агааргүйдэх ослоос болж хохирсон бол эд материалын хохирол амссан бичил уурхай эрхлэгчдийн 50.0 хувь нь шороонд дарагдах ослоос, 25.0 хувь нь нүхэнд унах ослоос, 10.0 хувь нь агааргүйдэх ослоос болж хохирсон байна.

Зураг 20. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдэд учирсан хохирлын төрөл, хувиар



Судалгааны дүнгээр судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 94.5 хувь нь бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцдаа ямар нэгэн өвчин, эмгэг тусч байгаагүй бол үлдсэн 5.5 хувь нь өвчин, эмгэг тусч байжээ. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцад өвчин, эмгэг туссан иргэдийн 35.7 хувь нь ууц нурууны өвчин, 25.7 хувь нь амьсгалын тогтолцооны өвчин, 9.5 хувь нь хоол боловсруулах замын өвчин, 7.5 хувь нь зүрх, судасны тогтолцооны өвчин, 6.6 хувь нь яс, бүлчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин, 3.9 хувь нь арьс ба арьсан доорх ислэгийн өвчин, 3.0 хувь нь мэдрэлийн тогтолцооны өвчин, үлдсэн 8.0 хувь нь бусад төрлийн өвчнөөр өвчилсөн байна.

Зураг 21. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн өвчлөлт, хувиар, өвчний төрлөөр



Эндээс харахад бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй орчин болон ажлын онцлогоос хамаарч бичил уурхай эрхлэгчдийн ихэнх хувь нь амьсгалын тогтолцооны болон ууц нурууны өвчнөөр өвчилдөг байна.

Хүснэгт 28. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн өвчилсөн өвчин, хувиар, төрөл, ажилласан жилийн бүлгээр

Өвчний төрөл	БҮГД	Өвчний төрөл						
		0-1	2-3	4-5	6-7	8-9	10-11	12+
Амьсгалын тогтолцооны	100.0	5.7	22.3	16.6	10.2	8.9	12.7	23.6
Ууц нурууны	100.0	6.4	20.2	16.1	11.0	12.8	14.2	19.3
Хоол боловсруулах замын	100.0	3.4	15.5	22.4	10.3	17.2	12.1	19.0
Зүрх судасны тогтолцооны	100.0	-	17.0	10.6	6.4	14.9	27.7	23.4
Арьс ба арьсан доорх эслэгийн	100.0	8.3	12.5	16.7	12.5	16.7	16.7	16.7
Яс, булчингийн тогтолцоо ба холбох эдийн	100.0	10.0	12.5	10.0	17.5	10.0	15.0	25.0
Шээс, бэлгийн тогтолцооны эмгэгийн	100.0	-	12.5	18.8	12.5	18.8	12.5	25.0
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэгийн	100.0	-	14.3	7.1	14.3	28.6	14.3	21.4
Мэдрэлийн тогтолцооны	100.0	11.8	41.2	-	5.9	5.9	23.5	11.8
Халдварт ба шимэгчид зарим өвчнөөр	100.0	-	20.0	20.0	10.0	20.0	20.0	10.0
Бусад	100.0	11.1	11.1	22.2	22.2	11.1	-	22.2

Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх явцдаа өвчилж байсан өвчний төрлийг бичил уурхайд ажилласан жилээр нь авч үзвэл амьсгалын тогтолцооны өвчнөөр өвчлөгчдийн 22.3 хувь нь 2-3 жил, 16.6 хувь нь 4-5 жил ажилласан бол ууц нурууны өвчнөөр өвчлөгчдийн 20.2 хувь нь 2-3 жил, 19.3 хувь нь 12 ба түүнээс дээш жил ажилласан хүмүүс байна.

Хоол боловсруулах замын өвчнөөр өвчлөгчдийн 22.4 хувь нь 4-5 жил, 15.5 хувь нь 2-3 жил, зүрх, судасны тогтолцооны өвчнөөр өвчлөгчдийн 27.7 хувь нь 10-11 жил, 14.9 хувь нь 8-9 жил, шээс бэлгийн тогтолцооны эмгэгээр өвчлөгчдийн 25.0 хувь нь 12 ба түүнээс дээш жил, 18.8 хувь нь 4-5 жил ажилласан хүмүүс байна.

Харин гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэгээр өвчлөгчдийн 28.6 хувь нь 8-9 жил, 21.4 хувь нь 12 ба түүнээс дээш жил ажилласан хүмүүс байна. Мөн мэдрэлийн тогтолцооны өвчнөөр өвчлөгчдийн 41.2 хувь нь 2-3 жил, 23.5 хувь нь 10-11 жил, халдварт ба шимэгчид зарим өвчнөөр өвчлөгчдийн 20.0 хувь нь 2-оос дээш жил ажилласан хүмүүс байна.

Хүснэгт 29. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн өвчлөлт, хувиар, өвчний төрлөөр, бүсээр

Өвчний төрөл	БҮГД					
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаанбаатар
Амьсгалын тогтолцооны	100.0	29.3	28.7	34.4	4.5	3.2
Ууц нурууны	100.0	26.6	24.8	39.4	4.1	5.0
Хоол боловсруулах замын	100.0	48.3	27.6	24.1	-	-
Зүрх судасны тогтолцооны	100.0	34.0	36.2	29.8	-	-
Арьс ба арьсан доорх ислэгийн	100.0	25.0	54.2	12.5	-	8.3
Яс, булчингийн тогтолцоо ба холбох эдийн	100.0	15.0	35.0	37.5	-	12.5
Шээс, бэлгийн тогтолцооны эмгэгийн	100.0	37.5	50.0	12.5	-	-
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэгийн	100.0	7.1	64.3	21.4	-	7.1
Мэдрэлийн тогтолцооны	100.0	52.9	29.4	11.8	-	5.9
Бусад	100.0	21.1	47.4	31.6	-	-

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдээс эмнэлгийн тусламж авах боломжийн талаар асуухад нийт 6948 бичил уурхай эрхлэгчдийн 2672 хүн буюу 38.5 хувь нь үйл ажиллагаа эрхэлж буй сум, дүүргийнхээ эмнэлгээс тусламж авах боломжтой гэж үзжээ. Бичил уурхай эрхлэгчдийн хувьд хамгийн хол зайтай эмнэлэг 350 километрт байрладаг бол хамгийн ойр зайтай эмнэлэг 1 километрт байрлаж байна. Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй орд, газраас эмнэлэг хүрэх дундаж зай улсын хэмжээнд 33.8 км байна.

Хүснэгт 30. Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй сум, дүүргийн эмнэлгийн зай, километрээр

Бүс, аймаг, нийслэл	Хамгийн ойр зай /километр/	Хамгийн хол зай /километр/	Дундаж зай /километр/
Улсын дундаж	1.0	350.0	33.8
Баруун бүс	2.0	300.0	40.2
Баян-Өлгий	2.0	60.0	16.2
Говь-Алтай	4.0	285.0	34.7
Завхан	7.0	300.0	40.6
Увс	2.0	190.0	39.2
Ховд	2.0	200.0	51.9
Хангайн бүс	2.0	230.0	41.6
Архангай	8.0	75.0	63.7
Баянхонгор	9.0	180.0	41.1
Булган	10.0	115.0	61.9
Өвөрхангай	2.0	230.0	26.5
Хөвсгөл	10.0	120.0	49.5
Төвийн бүс	1.0	350.0	33.6
Дорноговь	4.0	120.0	33.0
Дундговь	9.0	50.0	22.7
Өмнөговь	2.0	350.0	67.0
Сэлэнгэ	1.0	300.0	25.0
Төв	2.0	60.0	13.6
Зүүн бүс	1.0	92.0	27.3
Хэнтий	1.0	70.0	19.4
Улаанбаатар	2.0	45.0	4.3

Бичил уурхай эрхэлж буй иргэдийн үйл ажиллагаа явуулж байгаа газраас тухайн сум, дүүргийн эмнэлэг орох зайг бүсийн түвшинд авч үзвэл, Баруун бүсийн хувьд хамгийн хол зайтай эмнэлэг нь Завхан аймагт (300 км) байдаг бол хамгийн ойр зайтай эмнэлэг нь Баян-Өлгий, Увс, Ховд аймагт (2 км) байдаг ажээ. Харин Хангайн бүсийн хувьд хамгийн хол зайтай эмнэлэг нь (230 км), хамгийн ойр зайтай эмнэлэг нь (2 км) байдаг бөгөөд тус бүр Өвөрхангай аймагт байдаг байна. Төвийн бүсийн бичил уурхай эрхлэгчдийн хувьд хамгийн хол эмнэлэг нь Өмнөговь (350 км) байдаг бол хамгийн ойр зайтай эмнэлэг нь Сэлэнгэ аймагт (1 км) байдаг байна. Зүүн бүсийн хувьд хамгийн хол эмнэлэг нь Хэнтий аймагт (70 км) байдаг бол хамгийн ойр зайтай эмнэлэг нь мөн л тус аймагт (1 км) байдаг байна. Улаанбаатар хотын бичил уурхай эрхлэгчдийн хувьд хамгийн хол зайтай эмнэлэг 45 километр оршдог бол хамгийн ойрхон нь 2 километр оршиж байна.



БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН НИЙГЭМ, ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгаанд хамрагдсан олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгч 5998 иргэдийн 71.6 хувь нь амьжиргаа сайжирсан гэж хариулжээ.

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН НИЙГЭМ, ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Энэ бүлэгт бичил уурхай эрхлэгчдийн 2016 онд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлснээр тэдний амьдралд гарсан өөрчлөлт, цаашилбал, тэдний тухайн сүм, дүүрэг, орон нутгийн хөгжилд оруулсан хувь нэмэр, төрийн болон төрийн бус байгууллагаас тэдэнд үзүүлсэн дэмжлэг, тусалцааны талаар авч үзнэ.

7.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 51.4 хувь 2016 онд даатгалд хамрагдсан гэж хариулсан байна. Давхардсан тоогоор 2985 иргэд буюу 96.9 хувь нь эрүүл мэндийн даатгалд, 1744 иргэд буюу 56.6 хувь нь нийгмийн даатгалд даатгуулсан байна.

Хүснэгт 31. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 2016 онд даатгалд хамрагдсан байдал, бүс, даатгалын төрөл, давхардсан тоогоор


	БҮГД	Даатгалд хамрагдаагүй	Даатгалд хамрагдсан	Нийгмийн даатгал	Эрүүл мэндийн даатгал
БҮГД	5 998	2 917	3 081	1 744	2 985
Баруун	2 527	1 223	1 304	573	1 263
Хангайн	935	478	457	234	451
Төвийн	2 202	1 057	1 145	807	1 104
Зүүн	164	99	65	47	61
Улаанбаатар	170	60	110	83	106

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 42.3 хувь нь Баруун бүсэд, 37.0 хувь нь Төвийн бүсэд, 15.1 хувь нь Хангайн бүсэд харьяалагдаж байгаа бол нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 46.3 хувь нь Төвийн бүсэд, 32.9 хувь нь Баруун бүсэд, 13.4 хувь нь Хангайн бүсэд тус тус ногдож байна.

7.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АМЬЖИРГААНЫ ӨӨРЧЛӨЛТ

Бичил уурхай эрхэлснээр давхардсан тоогоор 3753 иргэд өрхийн амьжиргааны орлогын эх үүсвэртэй, 610 иргэд байнгын ажлын байртай болжээ. Түүнчлэн, 766 иргэд хувийн тээврийн хэрэгсэлтэй, 248 иргэд хувийн сууцтай болсон байна.

Зураг 22. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, хувиар, амьжиргаанд өөрчлөлт орсон төрлөөр



Бичил уурхай эрхэлснээр амьжиргаанд гарсан өөрчлөлтийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад орлогын эх үүсвэртэй болсон иргэдийн эзлэх хувь 13.5 пунктээр, хувийн тээврийн хэрэгсэлтэй болсон иргэдийнх 1.6 пунктээр, хувийн сууцтай болсон иргэдийнх 0.7 пунктээр өссөн бол байнгын ажлын байртай болсон иргэдийнх 4.9 пунктээр, бусад байдлаар өөрчлөлт орсон иргэдийн эзлэх хувь 11.0 пунктээр буурсан байна.

Хүснэгт 32. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн амьжиргааны өөрчлөлт, хувиар, бүсээр


Бүс	Байнгын ажлын байртай болсон	Орлогын эх үүсвэртэй болсон	Хувийн сууцтай болсон	Хувийн тээврийн хэрэгсэлтэй болсон	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	37.4	38.9	14.1	25.5	43.6
Хангайн	16.7	15.5	23.8	24.8	12.8
Төвийн	35.1	38.3	48.8	42.6	40.2
Зүүн	4.9	3.6	1.6	1.8	-
Улаанбаатар	5.9	3.7	11.7	5.4	3.4

Байнгын ажлын байртай болсон гэж хариулсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 37.4 хувь нь Баруун бүсийн, 35.1 хувь нь Төвийн бүсийн, 16.7 хувь нь Хангайн бүсийн бичил уурхай эрхлэгчид байна. Орлогын эх үүсвэртэй болсон гэж хариулсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 38.9 хувь нь Баруун бүсэд, 38.3 хувь нь Төвийн бүсэд, 15.5 хувь нь Хангайн бүсэд үйл ажиллагаа явуулдаг байна. Харин хувийн сууцтай болсон гэж хариулсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 48.8 хувь нь Төвийн бүсэд, 23.8 хувь нь Хангайн бүсэд, 14.1 хувь нь Баруун бүсэд ногдож байгаа бол хувийн тээврийн хэрэгсэлтэй болсон гэж хариулсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 42.6 хувь нь Төвийн бүсэд, 25.5 хувь нь Баруун бүсэд, 24.8 хувь нь Хангайн бүсэд ногдож байна.

7.3 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Бичил уурхай эрхлэгчдээс нийгэм, орон нутагт оруулсан хувь нэмрийнх нь талаар судлахад тэдний 77.9 хувь нь ямар нэгэн хувь нэмэр оруулаагүй гэж хариулсан байна. Харин үлдсэн 22.1 хувь нь тодорхой хэмжээний хувь нэмэр оруулсан гэж хариулжээ.


Зураг 23. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийгэм, орон нутагт оруулсан хувь нэмэр



Нийгэм, орон нутагт хувь нэмэр оруулсан гэж хариулсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн орон нутагтаа оруулсан хувь нэмрийг ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл давхардсан тоогоор байнгын ажлын байр бий болсон гэж хариулсан бичил уурхай эрхлэгчдийн 65.2 хувь нь алт олборлогчид, 21.4 хувь нь жонш олборлогчид, 11.2 хувь нь нүүрс олборлогчид, 2.2 хувь нь бусад ашигт малтмал олборлогчид байна.

Түүнчлэн орон нутагт мөнгөн хандив өгсөн болон орон нутгийн тохижуулалтад биечлэн оролцсон бичил уурхай эрхлэгчдийн 61.7 болон 63.0 хувь нь алт олборлогчид, 33.2 болон 34.5 хувь нь жонш олборлогчид байна.

Зураг 24. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийгэм, орон нутагт оруулсан хувь нэмэр, хувиар, ашигт малтмалын төрлөөр



Байнгын ажлын байр бий болгосон гэж хариулсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 39.7 хувь нь Төвийн бүсийн, 26.8 хувь нь Баруун бүсийн, 19.2 хувь нь Хангайн бүсийн бичил уурхай эрхлэгчид байна. Орон нутгийн тохижуулалтад биечлэн оролцсон гэж хариулсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 72.4 хувь нь Төвийн бүсэд, 13.5 хувь нь Хангайн бүсэд, 11.3 хувь нь Баруун бүсэд үйл ажиллагаа явуулдаг байна. Орон нутагт хандив өгсөн гэж хариулсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 46.9 хувь нь Төвийн бүсэд, 23.7 хувь нь Хангайн бүсэд, 21.7 хувь нь Баруун бүсэд ногдож байна.

Хүснэгт 33. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн орон нутагт оруулсан хувь нэмэр, бүсээр, хувиар

Бүс	Байнгын ажлын байр бий болсон	Орон нутгийг тохижуулахад биечлэн оролцсон	Хандив өргөсөн	Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн ажилд оролцсон	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	26.8	11.3	21.7	29.3	8.0
Хангайн	19.2	13.5	23.7	16.5	6.3
Төвийн	39.7	72.4	46.9	48.0	14.3
Зүүн	2.7	2.2	4.1	3.6	-
Улаанбаатар	11.6	0.6	3.5	2.5	71.4



8

ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ, ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгаанд хамрагдсан олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгч 5998 иргэдийн 17.2 хувь нь тусламж, дэмжлэг авсан байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ, ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан авсан тусламж дэмжлэг болон бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг хэрхэн шийдвэрлэж буй талаар энэ бүлэгт авч үзсэн.

8.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ АВСАН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэхдээ авч байсан тусламж, дэмжлэгийн талаар асуухад тэдний 1032 нь буюу 17.2 хувь нь ямар нэгэн тусламж, дэмжлэг авч байсан гэж хариулсан бол харин 4966 нь буюу 82.8 хувь нь авч байгаагүй гэж хариулсан байна.

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад тусламж, дэмжлэг авсан хүний эзлэх хувь 0.8 пунктээр буурч, харин тусламж, дэмжлэг аваагүй хүний эзлэх хувь 0.8 пунктээр өссөн байна.

Хүснэгт 34. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн төрийн болон төрийн бус байгууллагаас тусламж, дэмжлэг авсан байдал, бүсээр

Бүс	БҮГД		Дэмжлэг авсан хүн		Дэмжлэг аваагүй хүн	
	2012	2016	2012	2016	2012	2016
БҮГД	8 702	5 998	1 568	1 032	7 134	4 966
Баруун	2 051	2 527	206	174	1 845	2 353
Хангайн	2 633	935	564	193	2 069	742
Төвийн	3 071	2 202	770	538	2 301	1 664
Зүүн	326	164	25	66	301	98
Улаанбаатар	621	170	3	61	618	109

Судалгааны дүнгээр Төвийн бүсээс 538 бичил уурхайчин, Хангайн бүсээс 193, Баруун бүсээс 174, Зүүн бүсээс 66, Улаанбаатар хотоос 61 бичил уурхайчин тус тус төрийн болон төрийн бус байгууллагын тусламж, дэмжлэгт хамрагдсан байна.

Судалгааны дүнгээр төрийн болон төрийн бус байгууллагаас ямар нэгэн тусламж, дэмжлэг авч байсан бичил уурхай эрхлэгчдээс давхардсан тоогоор 1339 хүн буюу 56.5 хувь нь сургалтад хамрагдаж, 924 хүн буюу 39.0 хувь нь мэргэжлийн зөвлөгөө авсан байна. Түүнчлэн 38 хүн буюу 1.6 хувь нь буцалтгүй тусламж, 29 хүн буюу 1.2 хувь нь хөнгөлөлттэй зээл, 9 хүн буюу 0.4 хувь нь хөнгөлөлттэй үнээр тоног төхөөрөмж авчээ.

Хүснэгт 35. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн төрийн болон төрийн бус байгууллагаас авсан тусламж, дэмжлэг, хувиар, бүсээр

Бүс	БҮГД	Сургалтад хамруулсан	Мэргэжлийн зөвлөгөө өгсөн	Тоног төхөөрөмж хөнгөлөлттэй үнээр өгсөн	Хөнгөлөлттэй зээл олгосон	Буцалтгүй тусламж олгосон	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	14.1	15.3	10.6	33.3	37.9	18.4	31.3
Хангайн	15.6	13.4	17.2	22.2	10.3	44.7	31.3
Төвийн	60.5	58.8	65.9	33.3	44.8	36.8	25.0
Зүүн	6.0	8.0	3.6	-	-	-	6.3
Улаанбаатар	3.8	4.6	2.7	11.1	6.9	-	6.3

Мэргэжлийн зөвлөгөө авсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 65.9 хувь нь Төвийн бүсэд, 17.2 хувь нь Хангайн бүсэд, 10.6 хувь нь Баруун бүсэд харьяалагдаж байгаа бол сургалтад хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 58.8 хувь нь Төвийн бүсэд, 13.4 хувь нь Хангайн бүсэд, 15.3 хувь нь Баруун бүсэд ногдож байна. Буцалтгүй тусламж авсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 36.8 хувь нь Төвийн бүсийн бичил уурхай эрхлэгчид байгаа бол 44.7 нь Хангайн бүсийнх байна.

8.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДЭД ТУЛГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Судалгаанд хамрагдсан бичил уул уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулахад 2350 буюу 39.2 хувь нь хүндрэл бэрхшээл тулгардаг гэж хариулсан бол 3648 нь буюу 60.8 хувь нь ямар нэгэн хүндрэл бэрхшээл тулгардаггүй гэж хариулжээ.

Хүндрэл бэрхшээлтэй тулгарсан хүний тоог бүсээр авч үзвэл Баруун бүсэд 1125 хүн, Төвийн бүсэд 745 хүн, Хангайн бүсэд 400 хүн, Зүүн бүсэд 36 хүн, Улаанбаатар хотод 44 хүн байна.

Хүснэгт 36. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдэд тулгардаг хүндрэл, бэрхшээл, бүсээр

Хүндрэл, бэрхшээлийн төрөл	БҮГД					
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаан-баатар
БҮГД	5 998	2 527	935	2 202	164	170
Хүндрэл, бэрхшээлтэй тулгараагүй хүний тоо	3 648	1 402	535	1 457	128	126
Хүндрэл, бэрхшээлтэй тулгарсан хүний тоо	2 350	1 125	400	745	36	44
Нийт хүндрэл, бэрхшээлийн тоо	10 894	4 227	1 591	4 538	243	295
Хууль, эрх зүйн орчин бүрдээгүй	1 564	575	199	745	13	32
Ашигт малтмалын гарц муу	2 484	1 041	369	881	119	74
Үйл ажиллагаа явуулах газар хязгаарлагдмал	2 144	824	368	881	13	58
Санхүүгийн асуудал хүндрэлтэй (зээл авах)	877	323	107	365	48	34
Тоног төхөөрөмж дутагдалтай, хүчин чадал муу	652	255	94	280	16	7
Зохион байгуулалтын асуудал хүндрэлтэй	629	242	104	275	4	4
Хяналт шалгалт, дарамт ихтэй	2 146	863	287	953	22	21
Татварын асуудал хүндрэлтэй	276	72	49	130	4	21
Бусад	122	32	14	28	4	44

Судалгааны дүнгээр хууль эрх зүйн орчин боломжийн түвшинд бүрдээгүй гэж 1564 бичил уурхай эрхлэгч (давхардсан тоогоор) хариулсны 47.6 хувь нь Төвийн бүсэд, 36.8 хувь нь Баруун бүсэд, 12.7 хувь нь Хангайн бүсэд ногдож байгаа бол ашигт малтмалын гарц муу байдаг гэж 2484 иргэн (давхардсан тоогоор) тодорхойлсны 41.9 хувь нь Баруун бүсэд, 35.5 хувь нь Төвийн бүсэд, 14.9 хувь нь Хангайн бүсэд ногдож байна. Түүнчлэн санхүүгийн асуудал хүндрэлтэй буюу зээл авахад хүндрэлтэй байдаг гэж 877 уурхайчин (давхардсан тоогоор) тодорхойлсон бөгөөд тэдний 41.6 хувь нь Төвийн бүсэд, 36.8 хувь нь Баруун бүсэд, 12.2 хувь нь Хангайн бүсэд тус тус ногдож байна.

Тоног төхөөрөмж дутагдалтай, хүчин чадал муу байдаг гэж 652 бичил уурхайчин (давхардсан тоогоор) хариулсан бөгөөд 42.9 хувь нь Төвийн бүсэд, 39.1 хувь нь Баруун бүсэд, 14.4 хувь нь Хангайн бүсэд ногдож байна. Зохион байгуулалтын асуудал хүндрэлтэй байдаг гэж 629 уурхайчин (давхардсан тоогоор) хариулсны 43.7 хувь нь Төвийн бүсийнх, 38.5 хувь нь Баруун бүсийнх, 16.5 хувь нь Хангайн бүсийнх байна.

Хяналт шалгалт, дарамт ихтэй байдаг гэж 2146 бичил уурхай эрхлэгч (давхардсан тоогоор) тодорхойлсон бөгөөд 44.4 хувь нь Төвийн бүсийнх, 40.2 хувь нь Баруун бүсийнх, 13.4 хувь нь Хангайн бүсийнх байна. Татварын асуудал хүндрэлтэй гэж 276 бичил уурхай эрхлэгч (давхардсан тоогоор) үзсэн бөгөөд үүний 47.1 хувь нь Төвийн бүсэд, 26.1 хувь нь Баруун бүсэд, 17.8 хувь нь Хангайн бүсэд ногдож байна.

Хүснэгт 37. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдэд тулгардаг хүндрэл, бэрхшээл, хувиар, төрөл, бүсээр

Хүндрэл, бэрхшээлийн төрөл	БҮГД					
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаан-баатар
Нийт хүндрэл, бэрхшээлийн тоо	100.0	38.8	14.6	41.7	2.2	2.7
Хууль, эрх зүйн орчин бүрдээгүй	100.0	36.8	12.7	47.6	0.8	2.0
Ашигт малтмалын гарц муу	100.0	41.9	14.9	35.5	4.8	3.0
Үйл ажиллагаа явуулах газар хязгаарлагдмал	100.0	38.4	17.2	41.1	0.6	2.7
Санхүүгийн асуудал хүндрэлтэй (зээл авах)	100.0	36.8	12.2	41.6	5.5	3.9
Тоног төхөөрөмж дутагдалтай, хүчин чадал муу	100.0	39.1	14.4	42.9	2.5	1.1
Зохион байгуулалтын асуудал хүндрэлтэй	100.0	38.5	16.5	43.7	0.6	0.6
Хяналт шалгалт, дарамт ихтэй	100.0	40.2	13.4	44.4	1.0	1.0
Татварын асуудал хүндрэлтэй	100.0	26.1	17.8	47.1	1.4	7.6
Бусад	100.0	26.2	11.5	23.0	3.3	36.1

Тулгарсан хүндрэл, бэрхшээлийг ашигт малтмалын төрлөөр авч үзвэл алт олборлогчдын 2048 (давхардсан тоогоор) буюу 22.4 хувь нь ашигт малтмалын гарц муу, 1853 (давхардсан тоогоор) буюу 20.3 хувь нь хяналт шалгалт, дарамт ихтэй, 1842 (давхардсан тоогоор) буюу 20.2 хувь нь үйл ажиллагаа явуулах газар хязгаарлагдмал гэж хариулжээ.

Жонш олборлогчдын 240 (давхардсан тоогоор) буюу 30.6 хувь нь ашигт малтмалын гарц муу, 123 (давхардсан тоогоор) буюу 15.7 хувь нь үйл ажиллагаа явуулах газар хязгаарлагдмал, 85 (давхардсан тоогоор) буюу 10.8 хувь нь хяналт шалгалт, дарамт ихтэй гэж хариулсан байна.

Хүснэгт 38. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдэд тулгардаг хүндрэл, бэрхшээл, ашигт малтмалын төрөл, давхардсан тоогоор

Хүндрэл, бэрхшээлийн төрөл	БҮГД						
		Алт	Нүүрс	Жонш	Гянт-болд	Үнэт чулуу	Бусад
Нийт хүндрэл, бэрхшээлийн тоо	10 894	9 136	194	784	486	124	170
Хууль, эрх зүйн орчин бүрдээгүй	1 564	1 355	26	81	53	23	26
Ашигт малтмалын гарц муу	2 484	2 048	21	240	114	28	33
Үйл ажиллагаа явуулах газар хязгаарлагдмал	2 144	1 842	30	123	87	28	34
Санхүүгийн асуудал хүндрэлтэй (зээл авах)	877	693	29	75	60	7	13
Тоног төхөөрөмж дутагдалтай, хүчин чадал муу	652	546	4	67	24	2	9
Зохион байгуулалтын асуудал хүндрэлтэй	629	539	4	52	29	2	3
Хяналт шалгалт, дарамт ихтэй	2 146	1 853	24	85	107	34	43
Татварын асуудал хүндрэлтэй	276	190	13	58	8	-	7
Бусад	122	70	43	3	4	-	2

Судалгааны дүнгээр нийт бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 4508 нь буюу 75.2 хувь нь засаг захиргааны байгууллагуудтай харьцахад хүндрэлгүй байдаг гэж хариулсан бол 1490 нь буюу 24.8 хувь нь хүндрэлтэй байдаг гэж хариулжээ. Давхардсан тоогоор орон нутгийн засаг захиргааны байгууллагатай харьцахад хүндрэлтэй байдаг гэж 890 бичил уурхайчин үзсэн бол 675 хүн мэргэжлийн хяналтын байгууллагыг харьцахад хүндрэлтэй байгууллага гэж тодорхойлжээ.


Харин татварын байгууллагыг харьцахад хүндрэлтэй байгууллагаар 160 уурхайчин нэрлэсэн бол хууль, хяналтын байгууллагыг 857 уурхайчин тодорхойлсон байна.

Хүснэгт 39. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн харилцахад хүндрэлтэй байдаг байгууллага, бүсээр

Байгууллагын төрөл	БҮГД					
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаан-баатар
БҮГД	5 998	2 527	935	2 202	164	170
Харьцахад хүндрэлтэй асуудал тулгардаггүй	4 508	1 932	763	1 523	160	130
Харьцахад хүндрэлтэй асуудал тулгардаг	1 490	595	172	679	4	40
Нийт хүндрэлтэй байгууллагын тоо	3 536	1 504	468	1 478	10	76
Орон нутгийн засаг захиргааны байгууллага	890	487	92	286	4	21
Мэргэжлийн хяналтын байгууллага	675	221	89	344	2	19
Татварын байгууллага	160	89	24	39	-	8
Хууль, хяналтын байгууллага	857	302	124	422	-	9
Ашигт малтмалын газар	197	102	29	59	2	5
Эрүүл мэндийн байгууллага	181	68	13	96	-	4
Халамжийн байгууллага	68	45	11	10	1	1
Нийгмийн даатгалын байгууллага	40	21	6	9	-	4
Бусад	468	169	80	213	1	5

Засаг захиргааны байгууллагатай харилцахад хүндрэлтэй байдаг гэж хариулсан иргэдийн 49.9 хувь нь газрын зөвшөөрөлтэй холбоотой асуудал, 28.9 хувь нь төрийн байгууллагын ажилтны хүнд суртал, 11.2 хувь нь эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахтай холбоотой асуудал, 5.0 хувь нь халамжийн үйлчилгээтэй холбоотой асуудал, 3.1 хувь нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авахтай холбоотой асуудал хүндрэлтэй байдаг гэж хариулжээ.

Зураг 25. Орон нутгийн засаг, захиргааны байгууллагатай харилцахад хүндрэлтэй байдаг асуудлын төрөл, хувиар



Судалгаанд хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн дээр дурдсан хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэсэн байдлыг бүсийн түвшинд авч үзэхэд хууль эрх зүйн дагуу шийдвэрлэсэн 20 асуудлын 35.0 хувь нь Баруун бүсэд, 30.0 хувь нь Төвийн болон Хангайн бүсэд тус тус ногдож байна. Гэрээ, хэлцэл хийж шийдвэрлэсэн 26 асуудлын 53.8 хувь нь Хангайн бүсэд, 19.2 хувь нь Баруун бүсэд, 15.4 хувь нь Төвийн бүсэд хамаарч байна.

Торгууль, төлбөр төлж шийдвэрлэсэн 38 асуудлын 65.8 хувь нь Төвийн бүсэд, 18.4 хувь нь Баруун бүсэд ногдож байгаа бол дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандсан 55 асуудлын 78.2 хувь нь Баруун бүсэд, 9.1 хувь нь тус тус Хангайн болон Төвийн бүсэд ногдож байна.

Харин 1345 бичил уурхай эрхлэгчийн асуудал шийдвэрлэгдээгүй байгаагаас 46.8 хувь нь Төвийн бүсийнх, 39.8 хувь нь Баруун бүсийнх, 10.7 хувь нь Хангайн бүсийнх байна.

Хүснэгт 40. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдэд тулгардаг хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэсэн байдал, бүсээр

Шийдвэрлэсэн байдал	БҮГД					
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаан-баатар
Шийдвэрлээгүй	1 345	535	144	630	2	34
Шийдвэрлэсэн	145	60	28	49	2	6
Дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандсан	55	43	5	5	1	1
Хууль, хяналтын байгууллагад хандсан	36	32	1	2	-	1
Холбогдох байгууллагатай зөвшилцөж тохиролцсон	37	7	13	12	1	4
Хууль, эрх зүйн дагуу шийдвэрлэсэн	20	7	6	6	-	1
Гэрээ, хэлцэл хийсэн	26	5	14	4	1	2
Торгууль, төлбөр төлсөн	38	7	4	25	-	2
Бэлэг, шан харамж, хахууль өгсөн	3	2	-	1	-	-
Бусад	1	-	1	-	-	-

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн олборлосон ашигт малтмалаа борлуулахад гардаг хүндрэл, бэрхшээлийн талаар судлан үзэхэд 1013 бичил уурхайчин буюу 16.9 хувь нь ямар нэгэн хүндрэл тулгардаг гэж хариулсан бол 4985 бичил уурхайчин буюу 83.1 хувь нь ашигт малтмалаа борлуулахад ямар нэгэн хүндрэлтэй асуудал гардаггүй хэмээн хариулсан байна.

Бичил уурхайчдын олборлосон ашигт малтмалыг ченжүүд зах зээлийн үнээс доогуур худалдан авдаг явдал нь тэдний хувьд хамгийн том хүндрэл болж байна. Хүндрэл тулгардаг гэж хариулсан 1013 бичил уурхайчдын 2731 (давхардсан тоогоор) асуудал байгаагийн 815 (давхардсан тоогоор) нь буюу 29.8 хувь нь дээрх хүндрэлийг нэрлэсэн байна.

Мөн орон нутагт албан ёсны худалдан авагч байхгүй байгаа явдал хүндрэл, бэрхшээлийн тоонд багтаж байгаа бөгөөд энэ хүндрэлийг 592 (давхардсан тоогоор) хүн нэрлэсэн байна.

Хүснэгт 41. Ашигт малтмал борлуулахад тулгардаг хүндрэл, бэрхшээл, ашигт малтмалын төрлөөр

Хүндрэл, бэрхшээлийн төрөл	БҮГД						
		Алт	Нүүрс	Жонш	Гянтболд	Үнэт чулуу	Бусад
БҮГД	5 998	4 865	135	685	157	44	112
Хүндрэл, бэрхшээл тулгараагүй хүний тоо	4 985	4 282	90	402	101	35	75
Хүндрэл, бэрхшээл тулгарсан хүний тоо	1 013	583	45	283	56	9	37
Нийт хүндрэл, бэрхшээлийн тоо	2 731	1 369	120	963	162	25	92
Орон нутагт албан ёсны худалдан авагч байхгүй	592	355	36	149	23	7	22
Орон нутагт албан ёсны сорьц олгох нэгж байхгүй	512	270	21	198	17	-	6
Ченжүүд зах зээлийн үнээс доогуур үнээр авдаг	815	485	25	210	56	9	30
Ашигт малтмалын үнэ тогтвортой бус байдаг	535	206	26	215	51	9	28
Ашигт малтмалын агуулга, чанар нь стандартад хүрдэггүй	256	43	7	185	15	-	6
Бусад	21	10	5	6	-	-	-



Ченжүүд зах зээлийн үнээс доогуур худалдан авдаг гэж хариулсан иргэдийн 59.5 хувь нь алт олборлогч, 25.8 хувь нь жонш олборлогч, 6.9 хувь нь гянтболд олборлогчид байна. Орон нутагт албан ёсны худалдан авагч байхгүй гэж хариулсан иргэдийн 60.0 хувь нь алт олборлогчид байна.

Харин ашигт малтмалын үнэ тогтвортой бус гэж хариулсан иргэдийн 40.2 хувь нь жонш олборлогчид, 38.5 хувь нь алт олборлогчид, 9.5 хувь нь гянтболд олборлогчид байна. Ашигт малтмалын агуулга, чанар нь стандартад хүрдэггүй хүндрэлийн 72.3 хувь нь жонш олборлогчдод, 16.8 хувь нь алт олборлогчдод тулгарч байна.

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн ашигт малтмал олборлолтын газрыг шийдвэрлэсэн байдлыг судлан үзэхэд 81.2 хувийнх нь газрын асуудлыг шийдвэрлээгүй, 18.8 хувийнх нь газрын асуудлыг шийдвэрлэсэн байна.

Бичил уурхай эрхлэгчдийн ашигт малтмал олборлолтын газрыг шийдвэрлэсэн байдлыг ашигт малтмалын төрлөөр авч үзвэл, алт олборлогчдын 88.0 хувь нь, нүүрс олборлогчдын 86.7 хувь нь, жонш олборлогчдын 27.3 хувь нь, гянтболд олборлогчдын 98.1 хувь нь, бусад төрлийн ашигт малтмал олборлогчдын 82.1 хувь нь тус тус газрын асуудлаа шийдвэрлээгүй байна.

Алт олборлогчдын 84.7 хувь, жонш олборлогчдын 58.4 хувь, бусад төрлийн ашигт малтмал олборлогчдын 50.0 хувь нь сум, дүүргийн засаг даргатай бичгээр гэрээ байгуулж газрын асуудлаа шийдвэрлэсэн байна.

Харин нүүрс олборлогчдын 50.0 хувь нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй аман гэрээ байгуулж ашигт малтмал олборлолтын газрын асуудлаа шийдвэрлэжээ. Түүнчлэн жонш олборлогчдын 31.9 хувь, бусад төрлийн ашигт малтмал олборлогчдын 21.4 хувь, нүүрс олборлогчдын 16.7 хувь, алт олборлогчдын 3.8 хувь нь тус тус засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гурвалсан гэрээ байгуулан ажилладаг байна.


Хүснэгт 42. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн ашигт малтмал олборлолтын газрыг шийдвэрлэсэн байдал, ашигт малтмалын төрлөөр

Төрөл	БҮГД	Алт	Нүүрс	Жонш	Гянтболд	Бусад
БҮГД	5 998	4 865	135	685	157	156
Шийдвэрлээгүй	4 869	4 283	117	187	154	128
Шийдвэрлэсэн	1 129	582	18	498	3	28
Сум/дүүргийн даргатай бичгээр гэрээ байгуулсан	801	493	3	291	-	14
Сум/дүүргийн даргатай аман гэрээ байгуулсан	12	9	-	2	1	-
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй бичгэн гэрээ	38	9	3	25	1	-
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй аман гэрээ	31	5	9	17	-	-
Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гурвалсан гэрээ	190	22	3	159	-	6
Аж ахуйн нэгжийн талбай дээр гэрээгүй ажилладаг	50	39	-	3	1	7
Бусад	7	5	-	1	-	1

Судалгаагаар бичил уурхай эрхлэгчдээс үйл ажиллагаагаа явуулахад төрийн болон төрийн бус байгууллагаас ямар төрлийн тусламж, дэмжлэг авахыг хүсдэг талаар асуухад давхардсан тоогоор тэдний 21.3 хувь нь үйл ажиллагаа явуулах газрын асуудлаа шийдвэрлүүлэхийг, 13.5 хувь нь хууль, эрх зүйн орчныг сайжруулахыг, 11.0 хувь нь

хариуцлагатай нөхөрлөлийн системийг нэвтрүүлэхийг, 10.8 хувь нь зээл, санхүүгийн тусламж авахыг, 9.9 хувь нь байгаль орчныг нөхөн сэргээхийг, 8.9 хувь нь техник, технологийн тусламж, дэмжлэг авахыг, 8.9 хувь нь албан ёсны бүртгэлтэй болохыг, 8.3 хувь нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг сайжруулахыг хүсдэг байна.

Зураг 26. Бичил уурхайн үйл ажиллагаа явуулахад төрийн болон төрийн бус байгууллагаас авахыг хүсэж буй тусламж, дэмжлэг, хувиар, төрлөөр



9

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгаанд хамрагдсан олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгч 5998 иргэдийн 56.3 хувь нь өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж ашиглаж байна.

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ


Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоног төхөөрөмжийн төрөл, тэдгээрийн ашиглалт, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлийг судлах зорилгоор судалгааны асуулгад тусгайлан бүлэг асуултууд тусгаж, мэдээллийг цуглуулсан билээ. Тоног төхөөрөмжийн ашиглалт нь бичил уурхайн эрхлэгчдийн бүтээмж, орлоготой шууд хамааралтай чухал үзүүлэлт юм.

9.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАЛТ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 74.3 хувь нь ямар нэгэн багаж, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа ашигладаг байна. Ашиглаж буй нийт тоног төхөөрөмжийн 56.3 хувь нь өөрийн эзэмшлийнх, 39.7 хувь нь хамтын эзэмшлийнх, 3.9 хувь нь түрээсийн тоног төхөөрөмж байна.

Тоног төхөөрөмжийн эзэмшлийн хэлбэрийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж 17.9 пунктээр буурч, харин хамтын эзэмшлийн тоног төхөөрөмж 15.1 пунктээр, түрээсийн тоног төхөөрөмж 2.7 пунктээр өсжээ.

Зураг 27. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ашиглаж буй тоног төхөөрөмжийн тоо, эзэмшлийн төрлөөр



Тоног төхөөрөмжийн тоог бүсээр авч үзвэл, Баруун бүсэд 11371 ширхэг, Төвийн бүсэд 8772 ширхэг, Хангайн бүсэд 3799 ширхэг, Улаанбаатар хотод 1715 ширхэг, Зүүн бүсэд 611 ширхэг ногдож байна.

Хүснэгт 43. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ашиглаж буй тоног төхөөрөмж, бүс, тоног төхөөрөмжийн төрлөөр

Бүс	БҮГД	Гар багаж (алх, хүрз, жоотуу зэрэг)	Металл хайх төхөөрөмж	Цахилгаан үүсгүүр	Агааржуулагч	Цохилтод өрөм (молоток)	Өргөх төхөөрөмж (лебелка)	Усан буу (скруббер)	Насос	Бага оврын цохилтод өрөм (комплект)	Бусад
БҮГД	26 268	13 606	1 458	1 950	559	2 126	1 065	1 051	501	567	3 385
Баруун	11 371	6 331	685	858	126	766	294	313	236	210	1 552
Хангайн	3 799	1 842	193	265	107	244	113	169	42	107	717
Төвийн	8 772	4 136	548	711	214	867	480	417	157	219	1 023
Зүүн	611	290	6	47	7	66	58	62	9	10	56
Улаанбаатар	1 715	1 007	26	69	105	183	120	90	57	21	37

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ашиглаж буй нийт тоног төхөөрөмж 26268 болж, өмнөх судалгааны дүнгээс 7887 буюу 23.1 хувиар буурсан байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ашиглаж буй тоног төхөөрөмжийн 51.8 хувийг гар багаж (алх, хүрз, жоотуу), 12.9 хувийг бусад төрлийн (шлюз, хувин сав, ачааны автомашин, бага оврын экскаватор зэрэг) тоног төхөөрөмж, 8.1 хувийг цохилтод өрөм, 7.4 хувийг цахилгаан үүсгүүр, 5.6 хувийг металл хайх төхөөрөмж, 4.1 хувийг өргөх төхөөрөмж, 4.0 хувийг усан буу, 2.2 хувийг бага оврын цохилтод өрөм, 2.1 хувийг агааржуулагч, 1.9 хувийг насос эзэлж байна.

Хүснэгт 44. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ашиглаж буй тоног төхөөрөмжийн нийт дүнд эзлэх хувь, төрлөөр

Тоног төхөөрөмжийн төрөл	Тоног төхөөрөмжийн тоо		Дүнд эзлэх хувь	
	2012	2016	2012	2016
Бүгд	34 155	26 268	100.0	100.0
Гар багаж (алх, хүрз, жоотуу зэрэг)	22 354	13 606	65.4	51.8
Металл хайх төхөөрөмж	1 265	1 458	3.7	5.6
Цахилгаан үүсгүүр	1 375	1 950	4.0	7.4
Агааржуулагч	694	559	2.0	2.1
Цохилтод өрөм (молоток)	2 147	2 126	6.3	8.1
Өргөх төхөөрөмж (лебедка)	1 345	1 065	3.9	4.1
Усан буу (скруббер)	694	1 051	2.0	4.0
Насос	986	501	2.9	1.9
Бага оврын цохилтод өрөм (компрессор)	697	567	2.0	2.2
Бусад	2 598	3 385	7.6	12.9

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад нийт дүнд эзлэх гар багажийн хувь 13.6 пунктээр, насосны эзлэх хувь 1.0 пунктээр буурч, харин бусад төрлийн тоног төхөөрөмжийн эзлэх хувь 5.3 пунктээр, цахилгаан үүсгүүрийнх 3.4 пунктээр, усан бууных 2.0 пунктээр, металл хайх төхөөрөмжийнх 1.9 пунктээр, цохилтод өрөмнийх 1.8 пунктээр, бага оврын цохилтод өрөм, өргөх төхөөрөмжийнх 0.2 пунктээр, агааржуулагчийн эзлэх хувь 0.1 пунктээр өсжээ.

Хүснэгт 45. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ашиглаж буй тоног төхөөрөмжийн тоо, хувиар, төрлөөр, бүсээр

Тоног төхөөрөмжийн төрөл	БҮГД					
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаанбаатар
Бүгд	100.0	43.3	14.5	33.4	2.3	6.5
Гар багаж (алх, хүрз, жоотуу зэрэг)	100.0	46.5	13.5	30.4	2.1	7.4
Металл хайх төхөөрөмж	100.0	47.0	13.2	37.6	0.4	1.8
Цахилгаан үүсгүүр	100.0	44.0	13.6	36.5	2.4	3.5
Агааржуулагч	100.0	22.5	19.1	38.3	1.3	18.8
Цохилтод өрөм (молоток)	100.0	36.0	11.5	40.8	3.1	8.6
Өргөх төхөөрөмж (лебедка)	100.0	27.6	10.6	45.1	5.4	11.3
Усан буу (скруббер)	100.0	29.8	16.1	39.7	5.9	8.6
Насос	100.0	47.1	8.4	31.3	1.8	11.4
Бага оврын цохилтод өрөм (компрессор)	100.0	37.0	18.9	38.6	1.8	3.7
Бусад	100.0	45.8	21.2	30.2	1.7	1.1

Хамгийн ихээр хэрэглэж байгаа тоног төхөөрөмжийг бүсээр авч үзвэл, Баруун бүсэд цахилгаан үүсгүүр, бусад төхөөрөмж, гар багаж, металл хайх төхөөрөмж, насосны 44.0-47.1 хувийг хэрэглэдэг бол Төвийн бүсэд агааржуулагч, бага оврын цохилтод өрөм, усан буу, цохилтод өрөм, өргөх төхөөрөмжийн 38.3-45.1 хувийг хэрэглэж байна.

9.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 4330 буюу 72.2 хувь нь ямар нэгэн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг байна. Тэдгээрээс эрэгтэй олборлогчдын 73.7 хувь, эмэгтэй олборлогчдын 62.1 хувь нь хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг байна.

Хүснэгт 46. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх, хүйсээр

Хүйс	БҮГД		Тийм		Үгүй	
	2012	2016	2012	2016	2012	2016
БҮГД	7 273	5 998	2 569	4 330	4 704	1 668
Эрэгтэй	6193	5 206	2 250	3 838	3 943	1 368
Эмэгтэй	1 080	792	319	492	761	300

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэж байгаа бичил уурхайн олборлогчдын эзлэх хувь 36.9 хувиар, үүнээс эрэгтэй олборлогчдын эзлэх хувь 37.4 хувиар, эмэгтэй олборлогчдын эзлэх хувь 32.6 хувиар өссөн байна.

Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг уул уурхай олборлогчдыг насны бүлгээр нь авч үзвэл, 35-39 насныхан 16.7 хувийг, 30-34 насныхан 16.7 хувийг, 40-44 насныхан 16.1 хувийг, 25-29 насныхан 14.1 хувийг, 45-49 насныхан 13.7 хувийг, 50-54 насныхан 10.0 хувийг, үлдсэн 12.7 хувийг бусад насныхан эзэлж байна.


Хүснэгт 47. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх, насны бүлгээр

Насны бүлэг	БҮГД		Тийм		Үгүй	
	2012	2016	2012	2016	2012	2016
БҮГД	7 273	5 998	2 569	4 330	4 704	1 668
10-14	6	1	1	-	5	1
15-17	61	10	14	7	47	3
18-19	110	62	42	45	68	17
20-24	895	376	362	249	533	127
25-29	1 158	863	416	610	742	253
30-34	1 238	983	425	721	813	262
35-39	1 168	987	394	724	774	263
40-44	1 033	964	367	697	666	267
45-49	848	787	304	593	544	194
50-54	490	586	163	431	327	155
55-59	200	260	55	169	145	91
60-64	50	91	20	60	30	31
65-69	14	23	6	20	8	3
70 +	2	5	-	4	2	1

Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 29 хүртэлх насны иргэдийн хөдөлмөр хамгааллын хувцасны хэрэглээний эзлэх хувь буурч, 30-аас дээш насны иргэдийн эзлэх хувь өссөн үзүүлэлттэй байна.

Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг олборлогчдыг боловсролын түвшингээр нь авч үзвэл боловсролгүй иргэд 2.0 хувийг, бага болон суурь боловсролтой иргэд 50.3 хувийг, бүрэн дунд боловсролтой иргэд 33.6 хувийг, техникийн болон тусгай мэргэжлийн боловсролтой иргэд 7.4 хувийг, дээд боловсролтой иргэд 6.7 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 28. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, боловсролын түвшингээр



Нийт хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг бичил уурхай эрхлэгчдийн каск хэрэглэдэг хүн Баруун бүсэд 526 иргэд, Хангайн бүсэд 207 иргэд, Төвийн бүсэд 395 иргэд, Зүүн бүсэд 67 иргэд, Улаанбаатарт 75 иргэд байгаа бол нүдний шил хэрэглэдэг бичил уул уурхай эрхлэгчдийн 852 иргэд нь Баруун бүсэд, 244 иргэд нь Хангайн бүсэд, 502 иргэд нь Төвийн бүсэд, 44 иргэд нь Зүүн бүсэд, 29 иргэд нь Улаанбаатарт байдаг байна.


Хүснэгт 48. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн хэрэглэдэг хөдөлмөр хамгааллын хувцас, төрлөөр, бүсээр (давхардсан тоогоор)


Бүс	БҮГД	Каск	Гутал	Маск	Хантааз	Бээлий	Нүдний шил	Чихэвч	Гэрэл	Бусад
БҮГД	15 652	1 270	1 984	2 168	652	4 083	1 671	624	3 182	18
Баруун	7 037	526	816	1 030	221	1 899	852	260	1 429	4
Хангайн	2 308	207	278	355	154	538	244	108	416	8
Төвийн	5 236	395	726	619	232	1 377	502	219	1 163	3
Зүүн	558	67	95	84	24	113	44	34	94	3
Улаанбаатар	513	75	69	80	21	156	29	3	80	-

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн хамгийн түгээмэл хэрэглэгддэг хөдөлмөр хамгааллын хувцас нь бээлий 4083, гэрэл 3182, маск 2168, гутал 1984, нүдний шил 1671, каск 1270 ширхэг байна.

Өмнөх судалгааны дүнгээр нийт бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 35.3 хувь нь ямар нэгэн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг байсан бол 2016 онд 72.2 хувьд хүрсэн байна. Нүүрс олборлогчдын 88.8 хувь, үнэт чулуу олборлогчдын 86.4 хувь, алт олборлогчдын 75.6 хувь, шохойн чулуу олборлогчдын 73.3 хувь, гянтболд олборлогчдын 72.0 хувь нь хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг болсон нь өмнөх судалгааны дүнгээс нүүрс олборлогчдын хөдөлмөр хамгааллын хувцасны хэрэглээний эзлэх хувь 2.7 пунктээр, үнэт чулуу олборлогчдынх 70.6 пунктээр, алт олборлогчдынх 46.4 пунктээр, шохойн чулуу олборлогчдынх 40.0 пунктээр, гянтболд олборлогчдын 62.2 пунктээр өссөн байна.

Зураг 29. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх, хувиар, ашигт малтмалын төрлөөр





10

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Бичил уурхай эрхлэгчдийн 2016 оны судалгаанд хамрагдсан иргэд бичил уурхайн үйл ажиллагаанаас нийтдээ 22071.5 сая төгрөгийн орлого олж, 8548.9 сая төгрөгийн зарлага гаргасан байна.

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Бичил уурхай эрхлэгчдийн судалгаагаар ашигт малтмалыг алт, нүүрс, жонш, гянтболд, шохойн чулуу, үнэт чулуу, элс, хайрга, бусад гэсэн 8 төрлөөр судаллаа. Энэ бүлэгт бичил уурхайн үйл ажиллагаанд туслах үйл ажиллагаа эрхлэгч, гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогчийн талаарх мэдээлэл ороогүй болно.

10.1 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд хамрагдсан 6948 бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 73.5 хувь буюу 5108 нь алт, 10.9 хувь буюу 754 нь жонш, 10.5 хувь буюу 730 нь нүүрс, 2.5 хувь буюу 172 нь гянтболд, 0.7 хувь буюу 48 нь үнэт чулуу, 0.2 хувь буюу 17 нь шохойн чулуу, 0.1 хувь буюу 7 нь элс хайрга, үлдсэн хувь нь бусад төрлийн ашигт малтмал олборлож байна.

Хүснэгт 49. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүсээр, ашигт малтмалын төрлөөр

Бүс	БҮГД	Алт	Нүүрс	Жонш	Гянтболд	Шохойн чулуу	Үнэт чулуу	Элс, хайрга	Бусад
Бүгд	6 948	5 108	730	754	172	17	48	7	112
Баруун	2 614	2 274	57	-	171	17	20	5	70
Хангайн	963	963	-	-	-	-	-	-	-
Төвийн	2 440	1 721	-	652	1	-	28	1	37
Зүүн	164	56	-	102	-	-	-	1	5
Улаанбаатар	767	94	673	-	-	-	-	-	-

Нийт бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн давхардсан тоогоор 62.4 хувь нь буюу 4761 иргэд ил хэлбэрийн орд газарт олборлолт явуулж байгаа бол 37.6 хувь нь буюу 2870 иргэд далд хэлбэрийн орд газарт олборлолт явуулж байна.

Ил хэлбэрийн орд газарт олборлолт явуулж байгаа иргэдийн 78.4 хувь нь алт, 14.6 хувь нь жонш, 2.4 хувь нь гянтболд, 2.3 хувь нь бусад төрлийн ашигт малтмал, 1.1 хувь нь нүүрс, 0.7 хувь нь үнэт чулуу, 0.4 хувь нь шохойн чулуу, 0.1 хувь нь элс, хайрга олборлож байна.

Хүснэгт 50. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, ашигт малтмалын төрөл, хэлбэрээр, давхардсан тоогоор

Ашигт малтмалын төрөл	БҮГД	Ил	%	Далд	%
БҮГД	7 631	4 761	100.0	2 870	100.0
Алт	5 708	3 732	78.4	1 976	68.9
Нүүрс	730	50	1.1	680	23.7
Жонш	765	697	14.6	68	2.4
Гянтболд	203	116	2.4	87	3.0
Шохойн чулуу	17	17	0.4	-	-
Үнэт чулуу	72	32	0.7	40	1.4
Элс, хайрга	8	6	0.1	2	0.1
Бусад	128	111	2.3	17	0.6

Харин далд хэлбэрийн орд газарт үйл ажиллагаа явуулж буй иргэдийн 68.9 хувь нь алт, 23.7 хувь нь нүүрс, 3.0 хувь нь гянтболд, 2.4 хувь нь жонш, 1.4 хувь нь үнэт чулуу, 0.6 хувь нь бусад төрлийн ашигт малтмал, 0.1 хувь нь элс хайрга олборлож байна.



10.2 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БҮЙ ТАЛБАЙ

Энэ хэсэгт бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж буй газрын зөвшөөрөл, талбайн хэмжээ, эвдрэл, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээлэл багтана. Судалгааны дүнгээр зөвшөөрөлтэй талбайд ажиллаж буй бичил уурхай эрхлэгчдийн тоо 2016 онд буюу 17.7 хувь болж, өмнөх судалгааны дүнгээс 4.9 пунктээр буурлаа.

Хүснэгт 51. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид, ашиглаж буй талбайн төрлөөр, бүсээр

Бүс	БҮГД		Зөвшөөрөлгүй талбайд ажиллаж байгаа хүний тоо		Зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байгаа хүний тоо	
	2012	2016	2012	2016	2012	2016
БҮГД	7 273	5 998	5 625	4 935	1 648	1 063
Баруун	1 982	2 527	1 523	2 139	459	388
Хангайн	2 183	935	1 936	731	247	204
Төвийн	2 236	2 202	1 914	1 886	322	316
Зүүн	251	164	163	98	88	66
Улаанбаатар	621	170	89	81	532	89


Зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байгаа бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүсээр авч үзвэл, Баруун бүсийн олборлогчдын 36.5 хувь нь, Хангайн бүсийн олборлогчдын 19.2 хувь, Төвийн бүсийн олборлогчдын 29.7 хувь нь, Зүүн бүсийн олборлогчдын 6.2 хувь нь, Улаанбаатар хотын олборлогчдын 8.4 хувь нь зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байгаа нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад Улаанбаатар хотын зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байгаа олборлогчдын тоо 23.9 пунктээр буурч, харин Төвийн бүсийнх 10.2 пункт, Баруун бүсийнх 8.6 пунктээр, Хангайн бүсийнх 4.2 пунктээр, Зүүн бүсийнх 0.9 пунктээр өссөн байна.

Хүснэгт 52. Зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байгаа бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид, ашигт малтмалын төрөл, ашиглаж байгаа талбайн төрлөөр

Ашигт малтмалын төрөл	БҮГД		Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газар		Аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар		Бусад	
	2012	2016	2012	2016	2012	2016	2012	2016
БҮГД	1 648	1 063	692	650	930	373	26	40
Алт	744	731	480	442	261	262	3	27
Нүүрс	543	30	33	1	493	24	17	5
Жонш	176	195	150	155	20	39	6	1
Гянтболд	153	57	3	30	150	26	-	1
Шохойн чулуу	-	14	-	12	-	2	-	-
Үнэт чулуу	5	1	-	-	5	1	-	-
Элс хайрга	12	3	12	2	-	-	-	1
Бусад	15	32	14	8	1	19	-	5

Нийт зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байгаа иргэдийг олборлож байгаа ашигт малтмалын төрлөөр нь авч үзэхэд 68.8 хувь нь алт олборлогчид, 18.3 хувь нь жонш олборлогчид, 5.4 хувь нь гянтболд олборлогчид, 2.8 хувь нь нүүрс олборлогчид, үлдсэн нь шохойн чулуу, үнэт чулуу, элс, хайрга болон бусад төрлийн ашигт малтмал олборлогчид байна.

Зураг 30. Зөвшөөрөлтэй талбайд бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид, хувиар, ашигт малтмалын төрөл, зөвшөөрлийн төрлөөр



Алт олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн ашиглаж буй зөвшөөрөлтэй талбайн 60.5 хувь нь орон нутгийн тусгай хэрэгцээний газар, 35.8 хувь нь аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар, үлдсэн 3.7 хувь нь бусад төрлийн зөвшөөрөлтэй байна. Харин нүүрс олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн ашиглаж буй зөвшөөрөлтэй талбайн 80.0 хувь нь аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар, 16.7 хувь нь бусад төрлийн лицензтэй газар, 3.3 хувь нь орон нутгийн тусгай хэрэгцээний газрын зөвшөөрөлтэй байна.

Жонш олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн ашиглаж буй зөвшөөрөлтэй талбайн 79.5 хувь нь орон нутгийн тусгай хэрэгцээний газар, 20.0 хувь нь аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар, үлдсэн 0.5 хувь нь бусад төрлийн зөвшөөрөлтэй, харин гянтболд олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн ашиглаж буй зөвшөөрөлтэй талбайн 52.6 хувь нь орон нутгийн тусгай хэрэгцээний газар, 45.6 хувь нь аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар, 1.8 хувь нь бусад төрлийн лицензтэй газар байна.


Хүснэгт 53. Бичил уурхайд ашиглаж буй газрын хэмжээ, эвдрэлд орсон газрын хэмжээ, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ, бүсээр

Бүс	Ашиглаж байгаа талбайн хэмжээ, га		Олборлолт явуулж эхэлснээс хойш эвдрэлд орсон талбайн хэмжээ, га		Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ, га	
	2012	2016	2012	2016	2012	2016
БҮГД	8 319.2	3 701.7	8 288.0	3 228.4	594.3	382.8
Баруун	2 871.3	499.5	4 741.0	583.9	78.6	220.7
Хангайн	1 584.8	924.7	808.8	886.0	146.9	55.2
Төвийн	2 113.2	1 276.3	1 217.0	801.0	4.3	102.4
Зүүн	558.9	110.4	521.2	66.7	356.5	4.2
Улаанбаатар	1 191.0	890.8	1 000.0	890.8	8.0	0.3

2016 оны байдлаар нийтдээ 3701.7 га талбайг бичил уурхайн үйл ажиллагааны зориулалтаар ашиглаж байна. Энэ талбайн 499.5 га буюу 13.5 хувь нь Баруун бүсэд, 924.7 га буюу 25.0 хувь нь Хангайн бүсэд, 1276.3 га буюу 34.5 хувь нь Төвийн бүсэд, 110.4 га буюу 3.0 хувь нь Зүүн бүсэд, 890.8 га буюу 24.1 хувь нь Улаанбаатар хотод байна.

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид ашигт малтмал олборлох хугацаанд нийт 3228.4 га талбайг эвдрэлд оруулсан бөгөөд 583.9 га буюу 18.1 хувь нь Баруун бүсэд, 886.0 га буюу 27.4 хувь нь Хангайн бүсэд, 801.0 га буюу 24.8 хувь нь Төвийн бүсэд, 66.7 га буюу 2.1 хувь нь Зүүн бүсэд, 890.8 га буюу 27.6 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Зураг 31. Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ, бүсээр



Нийт бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээг бүсээр авч үзвэл, Төвийн бүсэд 102.4 га болж өмнөх судалгааны дүнгээс 98.1 га-гаар, Баруун бүсэд 220.7 га болж 142.1 га-гаар нэмэгдсэн байна. Харин Улаанбаатар хотод 0.3 га болж 7.7 га-гаар, Хангайн бүсэд 55.2 га болж 91.7 га-гаар, Зүүн бүсэд 4.2 га болж 352.4 га-гаар тус тус буурсан байна. Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ нь олборлолт явуулж эхэлснээс хойш эвдрэлд орсон нийт талбайн 11.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 54. Борлуулсан ашигт малтмалын хэмжээ, ашигт малтмалын төрлөөр

Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	2012	2016
Алт	кг	354.6	212.0
Нүүрс	тонн	141 970.6	159 025.4
Жонш	тонн	38 482.7	20 818.3
Гянтболд	тонн	108.3	161.1
Шохойн чулуу	тонн	66.6	69.8
Үнэт чулуу	тонн	14.7	27.3

Судалгааны дүнгээр бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид 212.0 кг алт, 159.0 мянган тонн нүүрс, 20.8 мянган тонн жонш, 161.1 тонн гянтболд, 69.8 тонн шохойн чулуу, 27.3 тонн үнэт чулуу олборложээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад алт 142.6 кг буюу 40.2 хувь, жонш 17.6 мянган тонн буюу 45.9 хувиар буурсан бол нүүрс 17.0 мянган тонн буюу 12.0 хувь, гянтболд 52.8 тонн буюу 48.8 хувь, шохойн чулуу 3.2 тонн буюу 4.8 хувь, үнэт чулуу 12.6 тонн буюу 85.7 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 55. Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн олборлосон ашигт малтмалаа борлуулдаг нэгж, хувиар, бүсээр

Бүс	Аж ахуйн нэгжид	Баяжуулах үйлдвэрт	Хувь хүнд	Монгол банкинд	Бусад
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун	28.4	14.4	45.9	20.0	35.3
Хангайн	1.0	34.8	15.1	33.3	17.6
Төвийн	61.6	50.7	33.8	46.7	-
Зүүн	6.6	-	1.7	-	47.1
Улаанбаатар	2.4	-	3.4	-	-

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид олборлосон ашигт малтмалынхаа 91.2 хувийг хувь хүнд, 4.9 хувийг аж ахуйн нэгжид, 3.4 хувийг баяжуулах үйлдвэрт, 0.3 хувийг Монголбанкинд борлуулсан байна.

Алт олборлолт: Алт олборлох үйл ажиллагаанд оролцогч нийт 5108 иргэний 71.5 хувь нь хувиараа/дангаараа алт олборлогч, 23.8 хувь нь нөхөрлөл/хоршооны зохион байгуулалтад орсон нөхөрлөл болон хоршооны ахлагч/гишүүн, үлдсэн 4.8 хувь нь гэр бүлийнхээ алт олборлолтын үйл ажиллагаанд оролцогч, бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч байна.

Судалгаанд хамрагдсан алт олборлогчид 2016 онд нийт 212.0 кг алт олборлож, нэг граммыг дунджаар 68.1 мянган төгрөгөөр борлуулсан байна.

Хүснэгт 56. Алт олборлогчдын тоо, олборлосон алтны хэмжээ, дундаж үнэ, бүсээр


Бүс	Алт олборлогчдын тоо		Олборлосон алт, кг		Олборлосон 1 гр алтны дундаж үнэ, мянган төгрөг	
	2012	2016	2012	2016	2012	2016
Бүгд	10 458	5 108	354.6	212.0	52.9	68.1
Баруун	2 946	2 274	71.7	62.5	52.4	67.7
Хангайн	3 899	963	139.6	48.9	56.3	64.5
Төвийн	3 557	1 721	141.9	97.1	52.6	70.3
Зүүн	56	56	1.4	0.9	61.4	54.8
Улаанбаатар	-	94	-	2.7	-	63.9

Алт олборлогчдыг бүсээр авч үзвэл, нийт алт олборлогч иргэдийн 44.5 хувь буюу 2274 нь Баруун бүсэд, 33.7 хувь буюу 1721 нь Төвийн бүсэд, 18.9 хувь буюу 963 нь Хангайн бүсэд, 1.8 хувь буюу 94 нь Улаанбаатар хотод, 1.1 хувь буюу 56 иргэн нь Зүүн бүсэд харьяалагдаж байна.

Судалгаанд хамрагдсан нийт алт олборлогчдын 19.7 хувь нь Говь-Алтай аймагт, 12.5 хувь нь Өмнөговь аймагт, 12.1 хувь Сэлэнгэ аймагт, 11.3 хувь нь Ховд аймагт, 10.8 хувь нь Баянхонгор аймагт, 9.2 хувь нь Төв аймагт, 7.2 хувь нь Увс аймагт, 6.3 хувь нь Завхан аймагт, үлдсэн нь Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Дорнод, Хэнтий, Булган аймагт болон Улаанбаатар хотод байна.

Бичил уурхай эрхлэгчдийн борлуулсан алтны дундаж үнийг улсын дундажтай харьцуулан аймгаар авч үзвэл, Архангай аймагт 17.6 мянган төгрөг, Булган аймагт 15.4 мянган төгрөг, Хэнтий аймагт 12.1 мянган төгрөг, Дорнод аймагт 11.9 мянган төгрөг, Завхан аймагт 6.6 мянган төгрөг, Өмнөговь аймагт 4.9 мянган төгрөг, Ховд аймагт 3.7 мянган төгрөг, Улаанбаатар хотод 3.5 мянган төгрөг, Сэлэнгэ аймагт 2.6 мянган төгрөг, Хөвсгөл аймагт 1.0 мянган төгрөг, Увс аймагт 0.6 мянган төгрөгөөр бага, харин Төв аймагт 8.3 мянган төгрөг, Өвөрхангай аймагт 4.6 мянган төгрөг, Говь-Алтай аймагт 1.4 мянган төгрөг, Баянхонгор аймагт 1.2 мянган төгрөгөөр өндөр байна.

Зураг 32. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн борлуулсан нэг грамм алтны дундаж үнэ, аймаг, нийслэлээр, мянган төгрөг





Нүүрс олборлолт: Нүүрс олборлолтын үйл ажиллагаа эрхэлж буй нийт 730 иргэний 81.6 хувь нь гэр бүлийнхээ алт олборлолтын үйл ажиллагаанд оролцогч буюу бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч, 18.2 хувь нь хувиараа/дангаараа нүүрс олборлогч байна.

Нүүрс олборлогчдыг аймгаар авч үзэхэд, нийт нүүрс олборлогч иргэдийн 92.2 хувь нь Улаанбаатар хотод, 4.8 хувь нь Увс аймагт, 3.0 хувь нь Говь-Алтай аймагт харьяалагдаж байна.

Хүснэгт 57. Нүүрс олборлогчдын тоо, олборлосон нүүрсний хэмжээ, дундаж үнэ, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Нүүрс олборлогчдын тоо		Олборлосон нүүрс, мян.тн		Олборлосон 1 тн нүүрсний дундаж үнэ, мян.төг	
	2012	2016	2012	2016	2012	2016
Бүгд	1 368	730	142.0	159.0	22.0	24.0
Баян-Өлгий	5	-	0.1	-	82.2	-
Говь-Алтай	29	22	0.9	0.8	35.3	83.3
Увс	74	35	0.8	0.7	59.9	43.4
Улаанбаатар	1 260	673	140.2	157.5	21.7	23.6

Судалгаанд хамрагдсан нүүрс олборлогчид 2016 онд нийтдээ 159.0 мянган тонн нүүрс олборлосон бөгөөд өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 12.0 хувь буюу 17.0 мянган тонноор өссөн байна. 2016 онд нэг тонн нүүрсийг дунджаар 24.0 мянган төгрөгөөр борлуулсан бөгөөд энэ нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 2.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Жонш олборлолт: Жонш олборлолтын үйл ажиллагаа эрхэлж буй нийт 754 иргэний 78.0 хувь нь нөхөрлөл/хоршооны зохион байгуулалтад орсон нөхөрлөл болон хоршооны ахлагч/гишүүн, 13.0 хувь нь хувиараа/дангаараа жонш олборлогч, 9.0 хувь нь гэр бүлийнхээ жонш олборлолтын үйл ажиллагаанд оролцогч буюу бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч байна. Жонш олборлогчдыг аймгаар авч үзэхэд нийт жонш олборлогч иргэдийн 69.1 хувь буюу 521 нь Дундговь аймагт, 13.5 хувь буюу 102 нь Хэнтий аймагт, 10.2 хувь буюу 77 нь Дорноговь аймагт, 7.2 хувь буюу 54 нь Говьсүмбэр аймагт харьяалагдаж байна.

Хүснэгт 58. Жонш олборлогчдын тоо, олборлосон жоншны хэмжээ, дундаж үнэ, аймгаар

Аймаг, нийслэл	Жонш олборлогчдын тоо		Олборлосон жонш, мян.тн		1 тн жоншны дундаж үнэ, мян.төг	
	2012	2016	2012	2016	2012	2016
Бүгд	1 010	754	38.5	20.8	54.0	59.4
Говьсүмбэр	52	54	-	-	-	-
Дорноговь	328	77	21.4	5.8	46.4	54.7
Дундговь	406	521	8.0	8.7	63.7	60.8
Хэнтий	224	102	9.1	6.3	63.4	61.7

Судалгаанд хамрагдсан жонш олборлогчид 2016 онд нийт 20.8 мянган тонн жонш олборлосон бөгөөд өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 46.0 хувь буюу 17.7 мянган тонноор буурсан байна. 2016 онд нэг тонн жоншийг дунджаар 59.4 мянган төгрөгөөр борлуулсан бөгөөд энэ нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 5.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Гянтболд олборлолт: Гянтболд олборлолтын үйл ажиллагаа эрхэлж буй нийт 171 иргэний 79.7 хувь нь хувиараа/дангаараа гянтболд олборлогч, 11.6 хувь нь нөхөрлөл/хоршооны зохион байгуулалтад орсон нөхөрлөл болон хоршооны ахлагч/гишүүн, 8.7 хувь нь гэр бүлийнхээ гянтболд олборлолтын үйл ажиллагаанд оролцогч буюу бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгчид байна.

Гянтболд олборлогчдыг аймгаар авч үзэхэд нийт гянтболд олборлогч иргэдийн 72.5 хувь Ховд аймагт, 27.5 хувь Баян-Өлгий аймагт харьяалагдаж байна.

Хүснэгт 59. Гянтболд олборлогчдын тоо, олборлосон гянтболдын хэмжээ, дундаж үнэ, аймгаар

Аймаг, нийслэл	Гянтболд олборлогчдын тоо		Олборлосон гянтболд, тонн		1 кг гянтболдын дундаж үнэ, мянган төгрөг	
	2012	2016	2012	2016	2012	2016
Бүгд	305	171	108.3	161.1	9.3	12.0
Баян-Өлгий	213	47	95.0	29.2	9.7	13.3
Ховд	57	124	10.4	132.9	6.4	11.8
Сүхбаатар	35	-	2.8	-	5.9	-

Судалгаанд хамрагдсан гянтболд олборлогчид 2016 онд нийт 161.1 тонн гянтболд олборлосон бөгөөд өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 48.8 хувь буюу 52.8 тонноор өссөн байна. 2016 онд нэг кг гянтболдыг дунджаар 12.0 мянган төгрөгөөр борлуулсан бөгөөд энэ нь өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 2.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Бусад төрлийн ашигт малтмал олборлолт: Судалгаанд хамрагдсан нийт 6948 бичил уурхай эрхлэгчдийн 184 нь буюу 2.6 хувь нь шохойн чулуу, үнэт чулуу, элс, хайрга болон бусад төрлийн ашигт малтмал олборлодог байна.

Хүснэгт 60. Бусад төрлийн ашигт малтмал олборлогчдын тоо, аймгаар

Аймаг, нийслэл	БҮГД		Шохойн чулуу		Үнэт чулуу		Бусад	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Бүгд	184	100.0	17	100.0	48	100.0	119	100.0
Баян-Өлгий	59	32.1	17	100.0	-	-	42	35.3
Завхан	14	7.6	-	-	-	-	14	11.8
Увс	17	9.2	-	-	-	-	17	14.3
Ховд	22	12.0	-	-	20	41.7	2	1.7
Дорноговь	10	5.4	-	-	-	-	10	8.4
Өмнөговь	56	30.4	-	-	28	58.3	28	23.5
Дорнод	6	3.3	-	-	-	-	6	5.0

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчид 2016 онд 69.8 тонн шохойн чулуу олборлож, 1 тонныг дунджаар 558.7 мянган төгрөгөөр, 27.3 тонн үнэт чулуу олборлож, 1кг-ыг дунджаар 6.9 мянган төгрөгөөр борлуулсан байна.

10.3 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ОРЛОГО, ЗАРДАЛ

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид олборлосон ашигт малтмалаасаа нийтдээ 22071.5 сая төгрөгийн орлого олсон байна. Бүсээр авч үзвэл нийт борлуулалтын орлогын 6648.3 сая төгрөг буюу 30.1 хувь нь Баруун бүсэд, 3155.5 сая төгрөг буюу 14.3 хувь нь Хангайн бүсэд, 7922.7 сая төгрөг буюу 35.9 хувь нь Төвийн бүсэд, 448.5 сая төгрөг буюу 2.0 хувь нь Зүүн бүсэд, 3896.5 сая төгрөг буюу 17.7 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Хүснэгт 61. Үйл ажиллагааны нийт орлого, бүсээр

Бүс	Нийт орлого, сая төгрөг		Нийт дүнд эзлэх хувь	
	2012	2016	2012	2016
Бүгд	25 389.6	22 071.5	100.0	100.0
Баруун	4 890.7	6 648.3	19.3	30.1
Хангайн	7 820.7	3 155.5	30.8	14.3
Төвийн	8 903.5	7 922.7	35.1	35.9
Зүүн	735.4	448.5	2.9	2.0
Улаанбаатар	3 039.4	3 896.5	12.0	17.7

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагааны орлогыг аймгаар авч үзвэл, хамгийн их орлоготойд Улаанбаатар хот 3896.5 сая төгрөг, Ховд аймаг 2842.4 сая төгрөг, Төв аймаг 2640.8 сая төгрөг, Сэлэнгэ аймаг 2316.4 сая төгрөг, Өмнөговь аймаг 2100.8 сая төгрөгийн орлогоор орж байгаа бол хамгийн бага орлого олсон аймгуудад Өвөрхангай аймаг 429.0 сая төгрөг, Дорноговь аймаг 335.4 сая төгрөг, Архангай аймаг 111.0 сая төгрөг, Хөвсгөл аймаг 81.2 сая төгрөг, Дорнод аймаг 19.3 сая төгрөгийн орлогоор орж байна.

Зураг 33. Үйл ажиллагааны нийт орлого, аймгаар



Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид 2016 оны байдлаар нийтдээ 8548.9 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Нийт зардлын 28.5 хувийг шатахуун, шатах тослох материалын зардал, 25.6 хувийг цалингийн зардал, 10.2 хувийг машин, тоног төхөөрөмж түрээсэлсний зардал, 7.4 хувийг түүхий эд материалын зардал, 6.4 хувийг тээврийн зардал, 5.9 хувийг сэлбэг хэрэгслийн зардал, үлдсэн хувийг бусад зардал бүрдүүлж байна.

Хүснэгт 62. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагааны зардал, зардлын төрөл, ашигт малтмалын төрлөөр

Зардлын төрөл	БҮГД					Дүнд эзлэх хувь
		Алт	Нүүрс	Жонш	Бусад	
Бүгд	8 548.9	6 387.3	1 015.8	951.1	194.8	100.0
Цалин	2 189.9	1 235.7	545.7	393.0	15.4	25.6
Ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн	64.9	52.8	3.0	8.7	0.5	0.8
Шатахуун, шатах тослох материал	2 439.1	2 131.3	48.3	197.7	61.8	28.5
Тээврийн зардал	550.1	367.4	73.1	94.3	15.3	6.4
Хөдөлмөр хамгааллын зардал	279.8	228.7	25.9	16.1	9.1	3.3
Цахилгаан эрчим хүч, дулаан	114.2	37.3	66.9	8.0	2.1	1.3
Сэлбэг хэрэгсэл	501.4	305.8	146.5	39.5	9.6	5.9
Түүхий эд, материал	633.1	522.4	45.3	28.6	36.8	7.4
Зээлийн хүүгийн зардал	126.4	109.4	10.3	3.5	3.1	1.5
Машин, тоног төхөөрөмж түрээсэлсний зардал	872.5	732.8	11.6	124.9	3.2	10.2
Барилга, байшин түрээсэлсний зардал	32.3	30.7	0.5	0.7	0.4	0.4
Гамшгийн улмаас учирсан хохирлыг нөхөхөд	2.6	2.4	0.2	-	-	-
Газар эзэмшигчид төлсөн төлбөр, татаас	29.6	27.3	1.6	0.2	0.6	0.3
Байгаль орчныг нөхөн сэргээх зардал	128.6	115.8	0.5	10.5	1.8	1.5
Бусад	584.5	487.5	36.5	25.5	35.0	6.8

Нийт зардлын 1083.2 сая төгрөг буюу 12.7 хувь нь Баруун бүсэд, 2275.9 сая төгрөг буюу 26.6 хувь нь Хангайн бүсэд, 3719.6 сая төгрөг буюу 43.5 хувь нь Төвийн бүсэд, 397.8 сая төгрөг буюу 4.7 хувь нь Зүүн бүсэд, 1072.3 сая төгрөг буюу 12.5 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Хүснэгт 63. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагааны зардал, зардлын төрөл, бүсээр

Зардлын төрөл	БҮГД					
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаанбаатар
Бүгд	8 548.9	1 083.2	2 275.9	3 719.6	397.8	1 072.3
Цалин	2 189.9	37.3	765.7	718.5	121.5	547.0
Ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн	64.9	4.6	8.2	40.2	8.4	3.6
Шатахуун, шатах тослох материал	2 439.1	395.6	727.5	1 126.9	122.9	66.1
Тээврийн зардал	550.1	96.6	110.8	197.9	67.9	76.9
Хөдөлмөр хамгааллын зардал	279.8	40.9	75.0	126.0	12.3	25.6
Цахилгаан эрчим хүч, дулаан	114.2	6.7	21.7	10.1	7.0	68.7
Сэлбэг хэрэгсэл	501.4	72.2	107.2	151.9	23.5	146.5
Түүхий эд, материал	633.1	198.5	155.8	220.4	6.7	51.8
Зээлийн хүүгийн зардал	126.4	53.5	20.7	37.0	4.8	10.3
Машин, тоног төхөөрөмж түрээсэлсний зардал	872.5	15.4	56.3	775.8	11.4	13.6
Барилга, байшин түрээсэлсний зардал	32.3	1.0	-	30.5	0.2	0.5
Гамшгийн улмаас учирсан хохирлыг нөхөхөд	2.6	-	-	2.4	-	0.2
Газар эзэмшигчид төлсөн төлбөр, татаас	29.6	2.3	15.5	9.6	0.2	2.1
Байгаль орчныг нөхөн сэргээх зардал	128.6	10.8	46.8	65.6	4.7	0.8
Бусад	584.5	147.8	164.8	206.9	6.3	58.6

Судалгаанд хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 25.8 хувь нь улсад татвар, хураамж төлсөн байна. Татвар төлсөн нийт бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн 42.0 хувь нь Баруун бүсэд, 17.9 хувь нь Хангайн бүсэд, 30.9 хувь нь Төвийн бүсэд, 2.3 хувь нь Зүүн бүсэд, 7.0 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Хүснэгт 64. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид, бүс, татвар төлсөн эсэхээр

Бүс	БҮГД		Тийм		Үгүй	
	2012	2016	2012	2016	2012	2016
Бүгд	7 273	5 998	1 820	1 545	5 453	4 453
Баруун	1 982	2 527	707	649	1 275	1 878
Хангайн	2 183	935	479	276	1 704	659
Төвийн	2 236	2 202	583	477	1 653	1 725
Зүүн	251	164	39	35	212	129
Улаанбаатар	621	170	12	108	609	62


Нийт 349.7 сая төгрөгийн татвар, хураамж төлсний 91.8 сая төгрөг буюу 26.3 хувийг авто болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн татварт, 37.0 сая төгрөг буюу 10.6 хувийг орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн татварт, 100.5 сая төгрөг буюу 28.7 хувийг хувь хүний орлогын албан татварт, 3.5 сая төгрөг буюу 1.0 хувийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварт, 18.1 сая төгрөг буюу 5.2 хувийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт, 14.0 сая төгрөг буюу 4.0 хувийг гишүүнчлэлийн татварт, 25.1 сая төгрөг буюу 7.2 хувийг нэмэгдсэн өртгийн албан татварт, 16.0 сая төгрөг буюу 4.6 хувийг газрын хураамжид, 43.8 сая төгрөг буюу 12.5 хувийг бусад татвар, хураамжид төлсөн байна.

Хүснэгт 65. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн төлсөн татварын хэмжээ, бүс, зардлын төрлөөр, сая төгрөг

Бүс	БҮГД	Авто тээвэр болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар	Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн татвар	Хувь хүний орлогын албан татвар	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Гишүүнчлэлийн татвар	Нэмэгдсэн өртгийн албан татвар	Газрын хураамж (газрын эзлэлд)	Бусад
Бүгд	349.7	91.8	37.0	100.5	3.5	18.1	14.0	25.1	16.0	43.8
Баруун	61.5	33.3	5.0	7.7	1.5	5.6	1.6	-	6.3	0.6
Хангайн	64.9	15.2	12.2	28.2	0.5	0.9	0.8	-	3.0	4.0
Төвийн	173.1	36.2	7.7	61.1	0.3	3.7	10.8	25.1	0.2	28.0
Зүүн	19.0	2.7	5.1	3.1	0.2	6.4	0.6	-	0.1	0.9
Улаанбаатар	31.2	4.4	6.9	0.4	1.0	1.6	0.1	-	6.5	10.3

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн татвар төлөлтийг ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл, алт олборлогчдын 80.0 хувь, нүүрс олборлогчдын 4.1 хувь, жонш олборлогчдын 12.7 хувь, гянтболд олборлогчдын 1.0 хувь нь татвар төлжээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад татвар төлөлтөд алт олборлогчдын эзлэх хувь 1.9 пунктээр, гянтболд олборлогчдынх 6.4 пунктээр бүүрч, харин нүүрс олборлогчдынх 1.8 пунктээр, жонш олборлогчдынх 6.1 пунктээр өссөн байна.

Зураг 34. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн татвар төлөлт, хувиар, ашигт малтмалын төрлөөр



Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид 2016 онд 22071.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн, 15936.0 сая төгрөгийн нэмэгдэл өртгийг бий болгож, 6135.5 сая төгрөгийг завсрын хэрэглээнд зарцуулсан бөгөөд өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад нэмэгдэл өртөг 3870.1 сая төгрөг буюу 19.5 хувиар буурсан бол завсрын хэрэглээ 551.9 сая төгрөг буюу 9.9 хувиар өссөн байна. Нийт нэмэгдэл өртгийн 35.5 хувийг Баруун бүс, 10.6 хувийг Хангайн бүс, 31.4 хувийг Төвийн бүс, 1.2 хувийг Зүүн бүс, 21.3 хувийг Улаанбаатар хотын бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид бүрдүүлж байна.

Хүснэгт 66. Нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг, бүсээр, сая төгрөг

Бүс	Нийт орлого		Завсрын хэрэглээ		Нэмэгдэл өртөг	
	2012	2016	2012	2016	2012	2016
Бүгд	25 389.6	22 071.5	5 583.6	6 135.5	19 806.1	15 936.0
Баруун	4 890.7	6 648.3	654.9	985.5	4 235.7	5 662.8
Хангайн	7 820.7	3 155.5	2 009.3	1 465.9	5 811.4	1 689.5
Төвийн	8 903.5	7 922.7	2 194.5	2 912.0	6 708.9	5 010.8
Зүүн	735.4	448.5	402.6	262.9	332.8	185.6
Улаанбаатар	3 039.4	3 896.5	322.2	509.2	2 717.2	3 387.3

Нэмэгдэл өртгийн бүрэлдэхүүний бүтцийг авч үзвэл, цалин 2189.9 сая төгрөг буюу 13.7 хувь, ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж 64.9 сая төгрөг буюу 0.4 хувь, зээлийн хүүгийн зардал 126.4 сая төгрөг буюу 0.8 хувь, татвар хураамж 382.0 сая төгрөг буюу 2.4 хувь, үлдсэн 13172.8 сая төгрөг буюу 82.7 хувь нь үйл ажиллагааны ашиг эзэлж байна.

Хүснэгт 67. Нэмэгдэл өртөг, бүрэлдэхүүн хэсгээр, бүсээр, сая төгрөг

Нэмэгдэл өртгийн бүрэлдэхүүн	БҮГД						Дүнд эзлэх хувь
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаан- баатар	
Бүгд	15 936.0	5 662.8	1 689.5	5 010.8	185.6	3 387.3	100.0
Цалин	2 189.9	37.3	765.7	718.5	121.5	547	13.7
Авто болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар	91.8	33.3	15.2	36.2	2.7	4.4	0.6
Орлогын тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн татвар	37.0	5.0	12.2	7.7	5.1	6.9	0.2
Хувь хүний орлогын албан татвар	100.5	7.7	28.2	61.1	3.1	0.4	0.6
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	3.5	1.5	0.5	0.3	0.2	1.0	-
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	18.1	5.6	0.9	3.7	6.4	1.6	0.1
Гишүүнчлэлийн татвар	14.0	1.6	0.8	10.8	0.6	0.1	0.1
Нэмэгдсэн өртгийн албан татвар	25.1	-	-	25.1	-	-	0.2
Газрын хураамж	16.0	6.3	3.0	0.2	0.1	6.5	0.1
Бусад татвар	43.8	0.6	4.0	28.0	0.9	10.3	0.3
Ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж	64.9	4.6	8.2	40.2	8.4	3.6	0.4
Зээлийн хүүгийн зардал	126.4	53.5	20.7	37.0	4.8	10.3	0.8
Гамшгийн улмаас учирсан хохирлыг нөхөхөд	2.6	-	-	2.4	-	0.2	-
Газар эзэмшигчид төлсөн төлбөр	29.6	2.3	15.5	9.6	0.2	2.1	0.2
Тооцооны ашиг	13 172.8	5 503.5	814.6	4 030.0	31.7	2 792.9	82.7

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийт завсрын хэрэглээний 39.8 хувийг шатахуун, шатах тослох материалын зардал, 14.2 хувийг машин, тоног төхөөрөмж түрээсэлсний зардал, 10.3 хувийг түүхий эд материалын зардал, 9.0 хувийг тээврийн зардал, 8.2 хувийг сэлбэг хэрэгслийн зардал, 4.6 хувийг хөдөлмөр хамгааллын зардал, 2.1 хувийг байгаль орчин нөхөн сэргээхтэй холбогдсон зардал, 1.9 хувийг цахилгаан эрчим хүч, дулааны зардал, 0.5 хувийг байшин, барилга түрээсэлсний зардал, үлдсэн 9.5 хувийг бусад зардал бүрдүүлж байна.

Бүсээр авч үзвэл, нийт завсрын хэрэглээний 16.1 хувь нь Баруун бүсэд, 23.9 хувь нь Хангайн бүсэд, 47.5 хувь нь Төвийн бүсэд, 4.3 хувь нь Зүүн бүсэд, 8.3 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.



Хүснэгт 68. Үйл ажиллагааны завсрын хэрэглээ, бүрэлдэхүүн хэсэг, бүсээр, сая төгрөг

Завсрын хэрэглээний бүрэлдэхүүн	БҮГД						Дүнд эзлэх хувь
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	Улаан- баатар	
Бүгд	6 135.5	985.5	1 465.9	2 912.0	262.9	509.2	100.0
Түүхий эд, материал	633.1	198.5	155.8	220.4	6.7	51.8	10.3
Сэлбэг хэрэгсэл	501.4	72.2	107.2	151.9	23.5	146.5	8.2
Цахилгаан эрчим хүч, дулаан	114.2	6.7	21.7	10.1	7.0	68.7	1.9
Шатахуун, шатах тослох материал	2 439.1	395.6	727.5	1 126.9	122.9	66.1	39.8
Барилга, байшин түрээсэлсний зардал	32.3	1.0	-	30.5	0.2	0.5	0.5
Машин тоног төхөөрөмж түрээсийн зардал	872.5	15.4	56.3	775.8	11.4	13.6	14.2
Тээврийн зардал	550.1	96.6	110.8	197.9	67.9	76.9	9.0
Хөдөлмөр хамгааллын зардал	279.8	40.9	75.0	126.0	12.3	25.8	4.6
Байгаль орчныг нөхөн сэргээх зардал	128.6	10.8	46.8	65.6	4.7	0.8	2.1
Бусад зардал	584.5	147.8	164.8	206.9	6.3	58.6	9.5

10.4 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЛЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


Энэ хэсэгт тухайн бизнест 2016 онд оруулсан хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын үндсэн эх үүсвэрийн талаарх мэдээллийг авч үзсэн. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид 2016 онд 1455.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн бөгөөд өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад 692.8 сая төгрөг буюу 32.2 хувиар буурсан байна. Хөрөнгийн төрлөөр авч үзвэл, барилга байшинд 72.3 сая төгрөг буюу 5.0 хувь, тээврийн хэрэгсэлд 417.0 сая төгрөг буюу 28.6 хувь, тоног төхөөрөмжид 899.1 сая төгрөг буюу 61.8 хувь, бусад хөрөнгөнд 67.4 сая төгрөг буюу 4.6 хувийн хөрөнгө оруулалт хийжээ.

Хүснэгт 69. 2016 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгийн төрөл, бүсээр, сая төгрөг

Бүс	БҮГД		Байшин, барилга		Тээврийн хэрэгсэл		Тоног, төхөөрөмж		Бусад	
	2012	2016	2012	2016	2012	2016	2012	2016	2012	2016
	2012	2016	2012	2016	2012	2016	2012	2016	2012	2016
Бүгд	2 148.6	1 455.8	244.1	72.3	1 211.7	417.0	654	899.1	38.9	67.4
Баруун	488.0	179.9	32.5	5.3	314.7	99.1	136.4	71.3	4.5	4.3
Хангайн	376.5	451.3	62.1	18.2	152.4	125.9	148.8	297.9	13.3	9.3
Төвийн	921.4	284.0	149.5	26.6	502.5	82.9	253.3	158.0	16.1	16.5
Зүүн	321.5	65.9	-	1.5	230.1	22.0	86.4	42.4	5.0	-
Улаанбаатар	41.1	474.7	-	20.7	12.0	87.2	29.1	329.5	-	37.3

Хөрөнгө оруулалтыг бүсээр авч үзвэл, Баруун бүсийн бичил уурхай эрхлэгчид 179.9 сая төгрөг, Хангайн бүсийнх 451.3 сая төгрөг, Төвийн бүсийнх 284.0 сая төгрөг, Зүүн бүсийнх 65.9 сая төгрөг, Улаанбаатар хотынх 474.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг тус тус хийсэн байна.

Зураг 35. 2016 онд хийсэн хөрөнгө оруулалтын хувь, бүсээр



Судалгаанд хамрагдсан бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 2016 онд хийсэн хөрөнгө оруулалтыг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад Хангайн бүсэд 13.5 пунктээр, Улаанбаатар хотод 30.7 пунктээр өссөн бол Баруун бүсэд 10.3 пунктээр, Зүүн бүсэд 10.5 пунктээр, Төвийн бүсэд 23.4 пунктээр буурсан байна.

Хүснэгт 70. Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн 2016 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, ашигт малтмалын төрөл, хөрөнгийн төрлөөр, сая төгрөг

Ашигт малтмалын төрөл	БҮГД		Байшин, барилга		Тээврийн хэрэгсэл		Тоног, төхөөрөмж		Бусад	
	2012	2016	2012	2016	2012	2016	2012	2016	2012	2016
Бүгд	2 148.6	1 455.8	244.1	72.3	1 211.7	417.0	654	899.1	38.9	67.4
Алт	1455.5	860.7	32.5	49.6	314.7	285.0	136.4	497.0	4.5	29.2
Нүүрс	53.1	466.7	62.1	20.7	152.4	79.7	148.8	329.0	13.3	37.3
Жонш	589.2	98.6	149.5	2.0	502.5	35.0	253.3	61.2	16.1	0.4
Гянтболд	8.4	19.4	-	-	230.1	14.3	86.4	4.6	5	0.5
Бусад	42.4	10.4	-	-	12	-	29.1	7.4	-	-

Алт олборлогчид 860.7 сая төгрөг, нүүрс олборлогчид 466.7 сая төгрөг, жонш олборлогчид 98.6 сая төгрөг, гянтболд олборлогчид 19.4 сая төгрөг, бусад ашигт малтмал олборлогчид 10.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад алт олборлогчдын хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 40.9 хувь, жонш олборлогчдынх 83.3 хувиар буурсан бол харин нүүрс олборлогчдынх 8.8 дахин, гянтболд олборлогчдынх 2.3 дахин өссөн байна.



ХАВСРАЛТ: АСУУЛГЫН ХУУДАС

Үндэсний статистикийн хорооны даргын 2016
оны 09-р сарын 19-ний өдрийн А/20 тоот
тушаалаар батлав.

А-БУЭС-1

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу мэдээллийн
нууцыг хадгална.

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГАА - 2016

БҮЛЭГ 1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Д/д	Асуулт	Хариулт
1.1	Судлаачийн овог, нэр, код	 Эцэг, эхийн нэр Нэр
1.2	Маягтын дугаар	
1.3	Шивэгчийн овог, нэр, код	 Эцэг, эхийн нэр Нэр
	Байршил	Үйл ажиллагаа явуулж байгаа газар Үндсэн захиргаа
1.4	Аймаг/нийслэл	Нэр Код Нэр Код
1.5	Сум/дүүрэг	
1.6	Баг/хороо	
1.7	Үйл ажиллагаа явуулж байгаа газрын байршил	Нийслэл-1, аймгийн төв-2, сумын төв-3, хөдөө-4
1.8	Ашигт малтмалын орд, газрын нэр	

БҮЛЭГ 2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Д/д	Асуулт	Хариулт	Алхам																																																						
2.1	Овог, нэр	 Эцэг, эхийн нэр Нэр																																																							
2.2	Регистрийн дугаар																																																								
2.3	Хүйс	Эрэгтэй Эмэгтэй	1 2																																																						
2.4	Холбоо барих утас																																																								
2.5	Нас (Бүтэн жилээр)																																																								
2.6	Та эзэмшсэн боловсролын дээд түвшнээ хэлнэ үү.	Боловсролгүй Бага Суурь Бүрэн дунд Техникийн болон мэргэжлийн Тусгай мэргэжлийн дунд Дээд	1 2 3 4 5 6 7																																																						
2.7	Та эзэмшсэн мэргэжлээ хэлнэ үү. (Үндсэн мэргэжлийг нөхнө.)	Мэргэжил код																																																							
2.8	Та өрхийн гишүүдийн талаарх мэдээллийг хэлнэ үү.	<table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">А</th> <th rowspan="2">Бүгд</th> <th colspan="2">Бичил уурхайд</th> </tr> <tr> <th>Эмэгтэй</th> <th>Эмэгтэй</th> </tr> <tr> <th>1</th> <th>2</th> <th>3</th> <th>4</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Ам бүл, бүгд</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Ажил эрхэлдэг</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td> ААНБ-д ажилладаг</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td> Хувиараа хөдөлмөр эрхлэгч</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Ажилгүй</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Тэтгэвэрт</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Их, дээд, сургууль, коллежид сурдаг</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Ерөнхий боловсролын сургуульд сурдаг</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Цэцэрлэгийн насны хүүхэд</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Цэцэрлэгт хамрагддаг хүүхэд</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Хөгжлийн бэрхшээлтэй</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	А	Бүгд	Бичил уурхайд		Эмэгтэй	Эмэгтэй	1	2	3	4	Ам бүл, бүгд				Ажил эрхэлдэг				ААНБ-д ажилладаг				Хувиараа хөдөлмөр эрхлэгч				Ажилгүй				Тэтгэвэрт				Их, дээд, сургууль, коллежид сурдаг				Ерөнхий боловсролын сургуульд сурдаг				Цэцэрлэгийн насны хүүхэд				Цэцэрлэгт хамрагддаг хүүхэд				Хөгжлийн бэрхшээлтэй				
А	Бүгд	Бичил уурхайд																																																							
		Эмэгтэй	Эмэгтэй																																																						
1	2	3	4																																																						
Ам бүл, бүгд																																																									
Ажил эрхэлдэг																																																									
ААНБ-д ажилладаг																																																									
Хувиараа хөдөлмөр эрхлэгч																																																									
Ажилгүй																																																									
Тэтгэвэрт																																																									
Их, дээд, сургууль, коллежид сурдаг																																																									
Ерөнхий боловсролын сургуульд сурдаг																																																									
Цэцэрлэгийн насны хүүхэд																																																									
Цэцэрлэгт хамрагддаг хүүхэд																																																									
Хөгжлийн бэрхшээлтэй																																																									

Багана 3-т 2-оос дээш гишүүд бичил уурхайд ажилладаг гэж нөхсөн бол асуулт 2.9-д хариулагчаас бусад бичил уурхайд ажилладаг өрхийн гишүүний мэдээллийг нөхнө.



БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН - 2016

Хуудас 2

Д/д	Асуулт	Хариулт	Алхам
2.9	Та бичил уурхайд ажилладаг өрхийн гишүүдийнхээ овог, нэр, регистрийн дугаарыг хэлнэ үү. (Энд хариулагчийн мэдээллийг нөхөхгүй.)		

БҮЛЭГ 3. АЖИЛ ЭРХЛЭЛТ

Д/д	Асуулт	Хариулт	Алхам
3.1	Та ажил эрхлэлтийн байдлаа хэлнэ үү.	Нөхөрлөлийн ахлагч/дарга Бүртгэгдсэн 1 Бүртгэгдээгүй 2 Нөхөрлөлийн гишүүн Бүртгэгдсэн 3 Бүртгэгдээгүй 4 Хоршооны Дарга 5 Гишүүн 6 Хувиараа (дангаараа) бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч 7 Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч 8 Гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч 9	3.3 3.3 3.8
3.2	Танай нөхөрлөл / хоршоо хэдэн гишүүнтэй вэ?	1. Нийт 2. Үүнээс эмэгтэй	
3.3	Та нөхөрлөл / хоршооныхоо нэр, регистрийн дугаарыг хэлнэ үү. (Бүртгэгдсэн нөхөрлөл / хоршооны ахлагч регистрийн дугаарыг заавал нөхнө.)		
3.4	Та төрийн бус байгууллагад харьяалагддаг уу?	Тийм 1 Үгүй 2	3.7
3.5	Та харьяалагддаг төрийн бус байгууллагынхаа нэр, регистрийн дугаарыг хэлнэ үү.		
3.6	Танай төрийн бус байгууллага "Монголын бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбоо"-ны гишүүн мөн үү?	Тийм 1 Үгүй 2 Мэдэхгүй 3	
3.7	Та болон тантай хамт ажилладаг хүмүүс орлогоо хэрхэн хуваарилдаг вэ? (Олон хариулттай байж болно.)	Орлогоо тэнцүү хуваарилдаг 1 Орлогоо хийснээр нь хуваарилдаг 2 Орлогоо тогтмол хувь хэмжээгээр хуваарилдаг 3 Орлогоо хуваарилдаггүй 4 Тогтмол цалинждаг 5	
3.8	Та бичил уурхайн үйл ажиллагаанд ямар үүрэгтэйгээр оролцдог вэ?	Ашигт малтмал олборлох 1 Бичил уурхайн туслах ажил гүйцэтгэх 2 Ашигт малтмал худалдан авах 3 Хүнс, барааны худалдаа эрхлэх 4 Хоолны газар ажиллуулах 5 Тээврийн үйлчилгээ эрхлэх 6 Гэр бүлийн бизнест цалин хөлсгүй ажиллах 7 Хөрөнгө оруулах 8	

Асуулгыг дуусгана.

Хуудас 3

Д/д	Асуулт	Хариулт	Алхам
3.9	Та бичил уурхайн үйл ажиллагааг хэдэн жил эрхэлж байна вэ? (Ажилласан жилийг анх гар аргаар ашигт малтмал олборлох болон түүнтэй хамааралтай үйл ажиллагаа явуулсан жилээс эхлэн тооцно.)	Жил	
